**МОНГОЛ УЛС**
**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**

Жанжин Д.Сүхбаатарын талбай 7, 1 дүгээр хороо,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0035
Утас: 32-71-99, Факс: (976-11) 32-21-47
http://www.ulaanbaatar.mn

2020. 01. 31 № 01/489

танай ______________-ны № ______________-т

НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД

Чиглэл өгөх тухай

Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор Төсвийн тухай хууль, Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 295, 2019 оны 282 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаи, дараах чиглэлийг үйл ажиллагаандаа баримтлан ажиллана уу. Үүнд:

Нэг.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд нийслэлд хэрэгжүүлсэн төслүүдийн гүйцэтгэл, хэрэгжилттэй холбогдуулан:

1.1.Засгийн газрын 2019 оны 249 дүгээр тогтоолыг үндэслэн тухайн зарим төсөл, арга хэмжээний 2019 онд санхүүжих дүнд санхүүжилтийн зохицуулалт хийгдсэн байгаа тул эдгээр төслүүдийн 2020 онд санхүүжих дүнг тухайн төсөлд ашиглахгүй байх, Засгийн газрын тогтоол 2020 онд батлагдсаны дагуу санхүүжилтийн зохицуулалтыг хийх;

1.2.Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолыг үндэслэн зарим төсөл, арга хэмжээний 2019 оны үлдэгдэл санхүүжилтийг банкны урьдчилгаа төлбөрийн баталгаанд үндэслэн олгосон, мөн захиалагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан тул эдгээр төслүүдийн гүйцэтгэлийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлж, Сангийн яамны зөвшөөрлөөр 2020 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор чөлөөлж дуусгах;

Хоёр.Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж болон бусад эх үүсвэрийн хөрөнгө оруулалтаар 2020 онд нийслэлд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй холбогдуулан:

2.1.Хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, мэдээ, ажлын явц, гүйцэтгэл, үр дүнгийн тайланг нийслэлийн төр, захиргааны байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсөвт байгууллагууд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэх;

2.2.Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, мэдээ, ажлын явц, гүйцэтгэл, үр дүнгийн тайланг батлагдсан маягтын боловсруулан батлуулж, зохих журмын дагуу холбогдох газарт хүргүүлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж ажиллах;

2.3.Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журмын хавсралтаар батлагдсан маягтын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний

гүйцэтгэлийг гарган захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст ирүүлэх, журмын 14 дүгээр зүйлд зааснаы дагуу www.publicinvestment.gov.mn цахим хуудас болон гар утасны "Төсвийн хөрөнгө оруулалт" аппликейшнээр дамжуулан хэрэгжүүлэх;

2.4.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг ашиглагч болон захиалагч байгууллагын шийдвэрээр нэмэлт ажил бий болгох, нэмэлт гэрээ хийхгүй байх;

2.5.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулах, гүйцэтгэлийн санхүүжилтийг 2020 оны төсвийн жилд багтаан санхүүжүүлэх талаар анхаарч ажиллах;

Хавсралт 56 хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ С.АМАРСАЙХАН

# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
# ТОГТООЛ

2019 оны 12 дугаар сарын 11-ний өдөр

Дугаар 430

Улаанбаатар хот

**Улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай**

Төсвийн тухай хуулийн 10.1.7, 10.1.14-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай:

1.1. боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд сургууль, цэцэрлэгийн барилгыг 2019-2020 онд бүрэн ашиглалтад оруулах, анхан шатлалын эмнэлгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хоёрдогч болон гуравдагч шатлалын эмнэлгүүдийн ачааллыг бууруулах, гаалийн бүртгэл, хяналтын тогтолцоог бэхжүүлж, нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилтыг хэрэгжүүлэх, өвөлжилтийн бэлтгэлийг хангах, салбарын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулиар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан банкны баталгааг үндэслэн олгох, зарим зайлшгүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчийн барьцаа хөрөнгийн дансанд байршуулах;

1.2. банкны баталгааг үндэслэн олгосон санхүүжилт болон барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан гүйцэтгэлд хяналт тавьж, баталгаажуулан 2020 оны 7 дугаар сарын 30-ны дотор Сангийн яаманд хүргүүлж, тус яамны зөвшөөрлөөр чөлөөлөх.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээг авч, хяналт тавьж ажиллахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд Ч.ХҮРЭЛБААТАР

# МОНГОЛ УЛСЫН
# САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 25 өдөр Дугаар 295 Улаанбаатар хот

Журам болон аргачлал батлах
тухай

/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалуудыг батлах тухай/

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам"-ыг 1 дүгээр, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал"-ыг 2 дугаар, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал"-ыг 3 дугаар, "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал"-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан журам, аргачлалыг хэрэгжүүлэх, төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Хөгжлийн бодлого, хөрөнгө оруулалтын хэлтсүүдэд хүргүүлэн мөрдүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т үүрэг болгосугай.

3. Холбогдох гарын авлага, маягт, сургалтын төлөвлөгөө болон хөтөлбөрийг 2019 оны 03 дугаар сарын 01-ний дотор багтаан боловсруулж, бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагчид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлж, холбогдох сургалтуудыг зохион байгуулахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т даалгасугай.

4. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг 2020 оноос эхлэн энэхүү батлагдсан журам, аргачлалын дагуу хэрэгжүүлэхийг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагчид, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн холбогдох хэсгийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, цахим системийн хамгаалалтыг хариуцан, хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /С.Дорждагва/-т, Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т тус тус даалгасугай.

6. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

614

Сангийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 25-ны өдрийн
295 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ҮНЭЛЖ, ЭРЭМБЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл, арга хэмжээг тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлаар нь эрэмбэлсний үндсэн дээр улсын төсөвт тусгах шийдвэр гаргах, төсвийн зардлыг бууруулах, төсвийн төлөвлөлт, удирдлагыг боловсронгуй болгоход оршино.

1.2. Энэхүү журам нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтад тусгах төслийг сонгох, төлөвлөх болон төсөвлөхтэй холбогдсон харилцаанд хамаарна.

1.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Барилгын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг удирдлага болгоно.

1.4. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын (цаашид "Сангийн яам" гэх) төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилтийг хангаж ажиллана.

1.5. Журмыг хэрэгжүүлэхэд уг журмын хамт Сангийн сайдын тушаалаар батлагдсан аргачлал, гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

## Хоёр. Нэр томьёо

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. "улсын төсөв" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.6-д заасныг;

2.1.2. "төсвийн ерөнхийлөн захирагч" гэж Төсвийн тухай хуулийн 4.1.36-д заасныг;

2.1.3. "төсөл" гэж улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй болон шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг;

2.1.4. "Аргачлал 1" гэж Сангийн сайдын тушаалын 2 дугаар хавсралт буюу "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал"-ыг;

2.1.5. "Аргачлал 2" гэж Сангийн сайдын тушаалын 3 дугаар хавсралт буюу "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал"-ыг;

2.1.6. "Аргачлал 3" гэж Сангийн сайдын тушаалын 4 дүгээр хавсралт буюу "Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал"-ыг;

2.1.7. "Ажлын хэсэг" гэж төслийг энэ журамд заасны дагуу үнэлж, эрэмбэлэх, сонгох чиг үүрэг бүхий Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалт болон тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн,

албан тушаалтан, бусад оролцогч талуудаас бүрдсэн орон тооны бус бүтцийг;

2.1.8. "Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын систем" (цаашид "Цахим систем" гэх) гэж төслийг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх, хяналт тавих, мэдээллийг хадгалах зориулалт бүхий цахим системийг.

## Гурав. Эрх бүхий байгууллагын чиг үүрэг

3.1. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төслийн төлөвлөлт, төсөвлөлт, удирдлага, зохион байгуулалтыг хариуцаж ажиллах бөгөөд энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1. төслийн саналыг энэ журамд заасны дагуу хүлээн авах, нэгтгэх;

3.1.2. төслүүдийг энэ журамд заасны дагуу эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслийг тодорхойлох, санал дүгнэлтийг гаргах;

3.1.3. шалгуур хангасан төсөлд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг тухайн жилийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар болон төсвийн төсөлд тусгуулах;

3.1.4. энэ журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллага, холбогдох этгээдээс гаргуулж авах;

3.1.5. Цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах;

3.1.6. энэхүү журам, аргачлалуудыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэргэжил, арга зүйн удирдлага, зохион байгуулалтыг хариуцан ажиллах, гарын авлагаар хангах, сургагч багш бэлтгэх, холбогдох сургалтыг зохион байгуулах.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, эсхүл мэргэжилтэн нь төслийг энэ журамд заасан тусгай шалгуур үзүүлэлтийн дагуу судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлыг үнэлж, эрэмбэлэх ажлыг зохион байгуулна.

3.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж, эсхүл мэргэжилтэн нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. төслийн саналыг холбогдох аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, үнэлэх,эрэмбэлэх;

3.3.2. төслийн саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, үнэлж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлох, сонгох, жагсаалт гаргах;

3.3.3. төслийг сонгон шалгаруулах үнэлгээг хийх Ажлын хэсгийг энэ журамд зааснаар байгуулан тухай бүр хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулах;

3.3.4. энэ журам болон холбогдох аргачлалд зааснаар үнэлж, эрэмбэлж сонгосны үндсэн дээр дараа оны төсвийн жилд хэрэгжүүлэх төслийн саналыг төсвийн төсөлд тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх;

3.3.5. энэ журамд заасан аргачлал, гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах;

3.3.6. энэхүү журмын хэрэгжилтийг хангахад Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжтэй хамтран ажиллах, хэрэгжилтийг тайлагнах.

3.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаанд тухайн байгууллага, салбарын голлох төлөөллүүдийг оролцуулсан 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус Ажлын хэсгийг байгуулж ажиллана.

3.5. Ажлын хэсэг нь холбогдох аргачлалд заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд тухайн төслийг хэрэгжүүлэхэд үүсэж болох эрсдэлийн олон талт хүчин зүйлийг үнэлж хэлэлцэх, түүнийг бууруулах шийдлийг тодорхойлох, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх чиглэл баримтлан ажиллана.

3.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Ажлын хэсгийг ахлах ба бүрэлдэхүүнд дараах этгээдийн оролцоог заавал хангана:

3.6.1. тухайн байгууллагын газар, хэлтэс;

3.6.2. дэд бүтцийн байгууллага, холбогдох этгээд;

3.6.3. тухайн төсөл нь бусад төсөл, хөтөлбөрүүдтэй уялдаатай бол холбогдох байгууллагын төлөөлөл;

3.6.4. холбогдох хот төлөвлөлт, газрын асуудал хариуцсан алба, нэгж.

3.7. Энэ журмыг хэрэгжүүлэхэд оролцож буй аливаа төрийн байгууллагын албан тушаалтан, мэргэжилтэн нь журмын биелэлтийг хангах чиг үүргээ мэргэжлийн түвшинд, хууль тогтоомжид нийцүүлэн, аливаа байгууллага, албан тушаалтнаас хараат бусаар, бие даан гүйцэтгэж, шийдвэр гаргана.

3.8. Энэхүү журам, аргачлалын дагуу Аймаг, нийслэлийн Засаг дарга нь төслийн саналыг тооцоо судалгаанд үндэслэн холбогдох аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэн сонгосны үндсэн дээр Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

3.9. Энэхүү журам болон холбогдох аргачлалд дурдсан шалгуур үзүүлэлтүүдийг үнэлэхэд холбогдох тооцоолол, үндэслэл, дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичгүүдийг Цахим системийн холбогдох цэсүүдэд оруулж, мэдээллийн бүрэн, үнэн зөв байдал, иж бүрдлийг хангасан байна.

## Дөрөв. Төсөлд тавигдах шаардлага

4.1. Төсөл нь Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, Монгол Улсын дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байна.

4.2. Төсөл нь дараах нийтлэг шаардлагыг хангасан байна. Үүнд:

4.2.1. Төсвийн тухай хууль, "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам" болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байх;

4.2.2. дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаарт багтсан байх;

4.2.3. тухайн салбарт хэрэгжиж буй Үндэсний болон дэд хөтөлбөрт хамаарах буюу суурилсан байх;

4.2.4. тухайн төслийн төрлөөс хамааран техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо, судалгаа болон Аргачлал 2-т заасны дагуу төслийн шинжилгээг хийсэн байх;

4.2.5. тухайн төслийн төрлөөс хамааран шаардлагатай тохиолдолд нийгмийн болон байгаль орчны нөлөөллийн шинжилгээг хийж, баталгаажуулсан байх.

4.3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн шинэ төслийн тухайд Аргачлал 2-ын дагуу төслийн эдийн засгийн үр ашиг,

нийгмийн ач холбогдлыг тооцох шинжилгээг хийсний үндсэн дээр Аргачлал 3-ын дагуу үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.4. Төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална. Үүнд:

4.4.1. шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл;

4.4.2. их засварын төсөл;

4.4.3. шинээр хэрэгжүүлэх төсөл.

4.5. Төсөл нь холбогдох Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

4.6. Төслийг энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлээгүй тохиолдолд улсын төсөвт тусгахаас татгалзах үндэслэл болно.

## Тав. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа

5.1. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь шинээр хэрэгжүүлэх төсөлд үнэлгээ хийх тухай албан бичгийг хэвлэмэл байдлаар болон цахимаар 04 дүгээр сарын 01-ний дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

5.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг Аргачлал 2, 3-т заасны дагуу Цахим системд үнэлж, төслийн жагсаалтыг 06 дугаар сарын 01-ний дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

5.3. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь ирүүлсэн төслийн саналыг Цахим системд нэгтгэн Аргачлал 2, 3-т заасны дагуу 07 дугаар сарын 01-ний дотор үнэлгээ хийгдсэн төслийг хянаж, сонгох үнэлгээ хийх төслийн жагсаалтыг гаргаж, төслийн жагсаалтыг төсвийн удирдамжийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагчид 07 дугаар сарын 05-ны дотор хүргүүлнэ.

5.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй шилжих төслийг Аргачлал 1-д заасны дагуу үнэлгээ хийж, шинээр хэрэгжүүлэх төслийн саналыг Аргачлал 2-т заасны дагуу сонгож, төсвийн төсөлд тусгуулах нийт төслийн саналаа 08 дугаар сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

5.5. Энэ журмын 5.4-т заасны дагуу ирүүлэх төсөл нь эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, газар нь чөлөөлөгдсөн, барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан байх шаардлагатай бөгөөд уг шаардлагыг хангаагүй төсөлд сонгох үнэлгээг хийхгүй.

5.6. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь ирүүлсэн төслүүдийг нэгтгэн, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй шилжих төслийг Аргачлал 1-д, шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийг Аргачлал 3-т заасныг баримтлан нийт төслийн жагсаалтыг боловсруулах ба тухайн жилийн төсвийн хязгаарыг үндэслэн эрэмбийн дагуу төсвийн төсөлд тусгана.

5.7. Энэхүү журмын 5.6-д зааснаас бусад Аргачлал 2-ын дагуу төслийн шинжилгээ хийгдсэн шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах төслүүдийг төсөвт тусгах асуудлыг "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам"-д заасны дагуу зохицуулна.

5.8. Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн, эсхүл нэгж нь төслийг холбогдох Аргачлалд заасныаар үнэлэхдээ Цахим системд тулгуурлан гүйцэтгэнэ.
5.9. Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ажлын хэсэг нь нийт төслийн жагсаалтыг гаргахдаа хэлэлцүүлэг зохион байгуулж, нэгдсэн шийдвэр гаргах ба хэлэлцүүлгийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг хавсаргана.
5.10. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар нь төсөвт тусгах хөрөнгө оруулалтын төслийг тодорхойлж, шийдвэрлэхдээ энэхүү журмын 4.4-т заасан эрэмбийг баримтлах үүрэгтэй.

## Зургаа. Бусад зүйл

6.1. Сангийн яам нь Цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх ба төслийн нийт саналыг цахимаар хүлээн авч, нэгтгэх, хянах, төслийн мэдээллийн санг бүрдүүлж, сангийн хамгаалалт, найдвартай байдлыг хангаж ажиллана.
6.2. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь Цахим системд нэвтрэх нэр, нууц үгийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэнд олгох бөгөөд тухайн мэргэжилтэн Цахим систем дэх өөрийн харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдээллийн үнэн зөв, баталгаатай байдлыг бүрэн хариуцан ажиллана.
6.3. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь цахим системд ажиллах хэрэглэгчийн гарын авлагыг бэлтгэж, Төсвийн ерөнхийлөн захирагч болон түүний харьяа байгууллагыг хангаж, сургагч багш нараар дамжуулан холбогдох сургалтыг тухай бүр зохион байгуулна.
6.4. Энэ журамд заасны дагуу үнэлж, эрэмбэлсэн төслийн жагсаалтыг www.iltod.gov.mn, https://mof.gov.mn цахим хуудаст тухай бүр шинэчлэн оруулж олон нийтэд ил тод мэдээлнэ.
6.5. Энэхүү журам болон Аргачлалыг хэрэгжүүлэх аливаа албан тушаалтан, мэргэжилтэн, Ажлын хэсгийн гишүүн нь чиг үүргээ төсвийн сахилга бат, мэргэжлийн ёс зүйг баримтлан, хууль ёсны дагуу, ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус, бие даан гүйцэтгэх ба тухайн этгээдийн хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.
6.6. Энэ журам болон холбогдох аргачлалд заасныг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Сангийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 25-ны өдрийн
195 тоот тушаалын 2 дугаар хавсралт

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛИЙГ ДАХИН ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

/Аргачлал – 1/

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Төсвийн хөрөнгө оруулалтыг зохистой удирдах, үр өгөөжийг нэмэгдүүлэх, төсвийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй бүх төслийг /цаашид "төсөл" гэх/ дахин үнэлэхэд энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Төслийг дахин үнэлэх үйл ажиллагаа нь дараах 3 үе шаттай байна. Үүнд:

1.2.1. төслийг ангилах;

1.2.2. төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах;

1.2.3. төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах, шийдвэрлэх.

1.3. Энэхүү аргачлалыг Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын систем (цаашид "Цахим систем" гэх)-д суурилан хэрэгжүүлнэ.

1.4. Цахим системийн "Шилжих төслүүдийг үнэлэх" цэсийг сонгож ажиллах ба дахин үнэлгээнд шаардагдах мэдээллийг оруулж, үнэлгээг хийнэ.

## Хоёр. Төслийг ангилах

2.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү аргачлалд заасны дагуу хэрэгжиж буй бүх төслүүдийг үнэлж, дараах байдлаар ангилна. Үүнд:

2.1.1. эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай;

2.1.2. хэвийн буюу үргэлжлүүлэх.

2.2. Төслийг дахин үнэлэхдээ санхүүжилтийн хүндрэл болон хэрэгжилт хангалтгүй гэсэн ерөнхий үзүүлэлтэд хамаарах 3 шалгуур үзүүлэлтийг ашиглаж, дараах байдлаар ангилна. Үүнд:

2.2.1. Төслийн санхүүжилтийн хүндрэлийг тогтооход төсөвт өртөг нэмэгдсэн, эсхүл санхүүжилт удааширсан эсэхийг тодорхойлж дараах байдлаар шалгана:

1) <u>Төсөвт өртгийн нэмэгдэл:</u> Төслийн санхүүжилтийн гүйцэтгэл болон нэмж шаардагдах санхүүжилтийн нийт дүн нь анхны төсөвт өртгөөс хэтэрсэн;

2) <u>Санхүүжилтийн хүндрэл:</u> Сүүлийн хоёр жилийн нийт санхүүжилт нь төсөвт өртгийн 20 буюу түүнээс бага хувьтай байсан;

2.2.2. Төслийн хэрэгжилт хангалтгүй байгааг тогтооход төслийн хэрэгжилт удааширсан эсэхийг дараах байдлаар шалгана:

1) <u>Хэрэгжилт удааширсан:</u> Төслийн хэрэгжиж дуусах хугацаа нь анх төлөвлөсөн хугацаанаас нэгээс дээш жилээр хэтрэх тохиолдолд;

*(Төслийг дахин үнэлж, шалгах ажиллагааг хүснэгтээр харуулав.)*

| Ангилал | Шалгуур үзүүлэлт | Томьёо |
|---|---|---|
| Санхүүжилтийн хүндрэл | <u>1) Төсөвт өртгийн нэмэгдэл:</u><br>Санхүүжилтийн гүйцэтгэл (СГ) болон нэмж шаардагдах санхүүжилт (НС) -ийн нийт дүн нь анхны төсөвт өртөг (ТӨ)-өөс хэтэрсэн; | $\frac{СГ + НС}{ТӨ} > 1$ |

| | | |
|---|---|---|
| | 2) Санхүүжилтийн хүндрэл:<br>Сүүлийн хоёр жилийн нийт санхүүжилт (С2ЖНС) нь төсөвт өртөг (ТӨ)–ийн 20 буюу түүнээс бага хувь ; | $С2ЖНС/ТӨ \leq 20\%$ |
| Хэрэгжилт хангалтгүй | 3) Хэрэгжилт удааширсан:<br>Төслийн хэрэгжиж дуусах хугацаа нь (ТХэ) анх төлөвлөсөн хугацаанаас (ТХу)-аас нэгээс дээш жилээр хэтрэх тохиолдолд; | $ТХэ - ТХу > 1$ жил |

2.3. Төсөл нь Аргачлалын 2.2-т заасан 3 шалгуур үзүүлэлтийн аль нэгд хамрагдсан тохиолдолд тухайн төслийг эргэлзээтэй буюу дахин үнэлэх шаардлагатай төслийн ангилалд оруулах бөгөөд төслийг цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулна.

2.4. Төсөл нь Аргачлалын 2.2-т заасан 3 шалгуур үзүүлэлтийн аль нэгд хамрагдаагүй тохиолдолд хэвийн буюу үргэлжлүүлэх төслийн ангилалд оруулах бөгөөд тухайн төслийг төсөвт тусгах үндэслэл болно.

2.5. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү аргачлалын дагуу төслүүдийг ангилж, төсөвт үргэлжлүүлэн тусгах хэвийн төслүүдийн жагсаалт болон эргэлзээтэй ангилалд оруулсан төслийг өөрчлөн хэрэгжүүлэх хувилбарын саналаа 08 дугаар сарын 15-ны дотор Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "Сангийн яам" гэх/-ын төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

2.6. Төсвийн ерөнхийлөн захирагч нь эргэлзээтэй ангилалд орсон дараах төслийг үргэлжлүүлэн төсөвт тусгах саналаа Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлж болно. Үүнд:

2.6.1. олон улсын гэрээгээр болон бусад гэрээгээр зайлшгүй хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн төсөл;

2.6.2. төслийн ажлын гүйцэтгэл 80-аас дээш хувьтай;

2.6.3. төслийн санхүүжилтийн гүйцэтгэл 80-аас дээш хувьтай;

## Гурав. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэхүү Аргачлалын 2 дах бүлэгт заасан ангиллын дагуу эргэлзээтэй ангилалд орсон төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг дараах хувилбараар боловсруулна. Үүнд:

3.1.1. <u>Төслийг шинэчлэн хэрэгжүүлэх:</u> энэ хувилбарыг төслийн хүчин чадал, эсхүл зориулалтыг өөрчлөх тохиолдолд сонгоно.

3.1.2. <u>Төслийг хойшлуулах:</u> төслийг нэг болон түүнээс дээш жилээр хойшлуулахад ач холбогдол нь хэвээр хадгалагдах болон нэмэгдэх тохиолдолд энэ хувилбарыг сонгоно.

3.1.3. <u>Төслийг зогсоох, дуудлагаар худалдах:</u> энэхүү аргачлалын 3.1.1 болон 3.1.2-т заасан хувилбарт хамрагдаагүй тохиолдолд төслийг зогсоож, дуусаагүй барилга байгууламж, хөрөнгийг хуульд заасны дагуу дуудлагаар худалдана.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийг өөрчлөх хувилбар бүрт түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг гарын авлагад заасан маягтуудын дагуу боловсруулж, Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

3.3. Энэхүү аргачлалын 3.1.1-д заасны дагуу төслийг шинэчлэн хэрэгжүүлэх тохиолдолд тухайн төслийг шинэ төсөлд тооцож, холбогдох аргачлалын дагуу үнэлгээ хийнэ.

## Дөрөв. Төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хянах, шийдвэрлэх

4.1. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь Төсвийн ерөнхийлөн захирагчаас ирүүлсэн шилжиж буй төслийн ангилал, төслийг өөрчлөн хэрэгжүүлэх төлөвлөгөөний саналыг үндэслэн холбогдох журамд заасны дагуу шийдвэрийг гаргана.

Сангийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 25-ны өдрийн
295 тоот тушаалын 3 дугаар хавсралт

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР АШИГ, НИЙГМИЙН АЧ ХОЛБОГДЛЫГ ТООЦОХ АРГАЧЛАЛ

/Аргачлал – 2/

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх бүх төрлийн төсөл /цаашид “төсөл” гэх/-ийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тогтооход энэхүү аргачлалыг ашиглана.

1.2. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлэхэд холбогдох гарын авлагыг баримтлан ажиллана.

1.3. Тус аргачлалын хэрэгжилтийн үр дүн нь Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал (цаашид “Аргачлал 2” гэх)-д заасан үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтээр төслийг үнэлэхэд ашиглах үндэслэл, суурь мэдээллийг бүрдүүлнэ.

1.4. Төсвийн тухай хуулийн 28.7-д заасан дараах төсөлд энэхүү аргачлалын 2.1-д заасан төслийн шинжилгээ хамаарахгүй ба Аргачлал 2-т заасан шалгуураар үнэлж, эрэмбэлэх, сонгох ажиллагааг хэрэгжүүлнэ:

1.4.1. үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон төсөл, арга хэмжээ;

1.4.2. байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах, нөхөн сэргээх төсөл, арга хэмжээ.

## Хоёр. Төслийн шинжилгээ хийх аргууд

2.1. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцохдоо төслийн шинжилгээний дараах 3 аргыг ашиглана. Үүнд:

2.1.1. зардал-үр ашгийн шинжилгээ /бүрэн болон хялбаршуулсан/;

2.1.2. зардал-үр дүнгийн шинжилгээ;

2.1.3. хамгийн бага зардлын шинжилгээ.

2.2. Төслийн шинжилгээ нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Төсвийн тухай хуулийн 28.3-т заасны дагуу үнэн зөв, бодитой мэдээлэлд үндэслэсэн байна;

2.2.2. холбогдох гарын авлагын дагуу боловсруулж, тухайн төслийг үнэлж, дүгнэх нөхцөлийг хангасан байна.

2.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийн шинжилгээ хийх чиг үүргийг хариуцна.

2.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2.1-д заасан төслийн шинжилгээний аргыг дараах нөхцөлд ашиглана. Үүнд:

2.4.1. зардал, үр ашгийг бүрэн үнэлж тооцох боломжтой 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төслүүдэд зардал-үр ашгийн бүрэн шинжилгээг;

2.4.2. 15.0 – 30.0 тэрбум хүртэлх төгрөгийн төсөвт өртөгтэй төслүүдэд зардал-үр ашгийн хялбаршуулсан шинжилгээг;

2.4.3. 15.0 тэрбум төгрөгөөс бага төсөвт өртөгтэй буюу ижил төстэй төслүүдийг олноор хэрэгжүүлдэг салбарт тэдгээрийг харьцуулан өрсөлдүүлэх зорилгоор тухайн төслүүдэд зардал-үр дүнгийн шинжилгээ болон хамгийн бага зардлын шинжилгээг.

2.5. Төслийн зардал-үр ашгийн шинжилгээг тухайн төслийн санхүү, эсхүл эдийн засгийн үр ашгийг тооцож, тогтсон жишиг үзүүлэлттэй харьцуулж хамгийн ашигтай төслийг тодорхойлж эрэмбэлэхэд ашиглана.

2.6. Зардал-үр дүнгийн болон хамгийн бага зардлын шинжилгээг нэгж ажил, үйлчилгээнд ногдох зардлыг тооцож, ижил ажил, үйлчилгээ үзүүлэх төслүүдийг хооронд нь харьцуулж хамгийн бага зардлаар зорилт, үр дүнд хүрэх төслийг тодорхойлж эрэмбэлэхэд ашиглана.

2.7. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь 30.0 тэрбум төгрөгөөс дээш төсөвт өртөгтэй төслийн шинжилгээний үр дүнг хянаж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болохыг тогтооно.

2.8. Төсвийн ерөнхийлөн захирагч нь 30.0 тэрбум төгрөгөөс бага төсөвт өртөгтэй төслийн шинжилгээний үр дүнг хянаж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болохыг тогтооно.

2.9. Сангийн яам нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл нь үр дүнтэй болох нь тогтоогдсон нөхцөлд төсөвт тусгана.

2.10. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийн шинжилгээнд ашиглах тухайн салбарын ажил, үйлчилгээний стандартыг Сангийн яамтай хамтран тогтооно.

2.11. Төслийн шинжилгээг хийж холбогдох тооцооллыг гаргахдаа тухайн өдрийн зах зээлийн үнийг баримтална.

2.12. Төслийн шинжилгээний гарын авлагад дурдсан жишиг маягтуудыг Цахим системийн “жишиг баримт бичиг” гэсэн цэсээс авч ашиглана.

## Гурав. Төслийн шинжилгээний үр дүнг хянаж, үнэлгээ хийх

3.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төслийн шинжилгээний үр дүн, тооцоолол, үндэслэл, дэлгэрэнгүй мэдээллийг Цахим системийн “төслийн дэлгэрэнгүй мэдээлэл” цэсийн холбогдох талбарт бичиж, нотлох баримтуудыг файлаар оруулсан байна.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь 3.1-д дурдсан баримт бичгийг иж бүрдэл болгон Сангийн яаманд бичгээр хүргүүлнэ.

3.3. Шинээр хэрэгжүүлэх төслийн шинжилгээний тайланд мэргэжлийн, хараат бус шинжээчийн дүгнэлтийг оруулсан байх ба Төсвийн ерөнхийлөн захирагчаас хянаж баталсан шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлнэ.

3.4. Сангийн яамны түвшинд төсөлд үнэлгээ хийх үйл ажиллагааг Аргачлал 3-ын дагуу дараах 2 үе шатаар хэрэгжүүлнэ:

3.4.1. хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн нь төслийн үнэлгээг дараах дараалыг баримтлан хийнэ. Үүнд:

3.4.1.1. төслийн шинжилгээний судалгаа, тайлан, тооцоо, холбогдох дүгнэлт зэрэг баримт бичгийн бүрдлийг шалгах;

3.4.1.2. төсөлд шинжилгээ хийхэд баримталсан тоо баримт, мэдээ мэдээллийн бодитой, үнэн зөв эсэхийг шалгах;

3.4.1.3. төслийн төсөвт өртөг, зардлыг бүрэн, зөв тооцсон эсэхийг хянах;

3.4.1.4. шаардлагатай тохиолдолд Сангийн яамны газар, хэлтсийн санал, дүгнэлтийг авсан байх;

3.4.1.5. төслийн шинжилгээний үр дүнг хүлээн зөвшөөрөх боломжтой тохиолдолд үнэлгээг зөвшөөрсөн товч дүгнэлт гаргах;

3.4.1.6. төслийн шинжилгээний үндэслэл хангалтгүй, нотлох баримт дутуу зэрэг тохиолдолд Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэргэжилтний үнэлгээний оноог бууруулах болон буцаах шалтгааныг дурдсан шийдвэрийн төслийг боловсруулах.

3.4.2. Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга нь Аргачлалын 3.4.1-ийн дагуу бэлтгэсэн мэргэжилтний тайланг хэлэлцэх ба шаардлагатай тохиолдолд төслийн үнэлгээний оноог засварлаж шинээр хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг тодорхойлно.

## Дөрөв. Төслийн үр ашгийг үнэлэх зарчим

4.1. Төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын шалгуур үзүүлэлтийг дүгнэж оноо өгөхөд дараах зарчмыг баримтална. Үүнд:

4.1.1. Зардал-үр ашгийн шинжилгээ хийгдсэн төслүүдийн хувьд Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын тогтоосон үр дүнгийн үзүүлэлтийг үндэслэх;

4.1.2. Зардал-үр дүнгийн болон хамгийн бага зардлын шинжилгээ хийгдсэн төслүүдийн хувьд сүүлийн 3 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй төслүүдтэй харьцуулах.

4.2. Энэхүү аргачлалын дагуу төслийн эдийн засгийн хувьд үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой болохыг тодорхойлж, баталгаажуулсан баримт бичиг, шийдвэр нь тухайн төсөл хэрэгжүүлж, үйл ажиллагааг эхлүүлсний дараа хийгдэх хүчин чадлын ашиглалтыг шалгаж дүгнэхэд баримтлах үндсэн баримт бичиг болно.

Сангийн сайдын 2018 оны
12 дугаар сарын 15-ны өдрийн
295 тоот тушаалын 4 дүгээр хавсралт

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ШИНЭЭР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ АРГАЧЛАЛ

/Аргачлал – 3/

## Нэг. Ерөнхий зүйл

1.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн төсөл (цаашид төсөл гэх)-ийг үнэлэх, эрэмбэлэх, сонгоход энэхүү аргачлалыг баримтална.

1.2. Энэхүү аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлэх, сонгох төсөл нь “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал” (цаашид “Аргачлал 3” гэх)-д заасны дагуу холбогдох шинжилгээ хийгдэж, төслийн суурь мэдээллийг бүрдүүлсэн байна.

1.3. Энэхүү аргачлалыг хэрэгжүүлэхэд Улсын хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (цаашид “Цахим систем” гэх)-ээр үнэлгээг хийх бөгөөд холбогдох гарын авлагыг баримтлан ажиллана.

## Хоёр. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагаа, үе шат

2.1. Төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааг дараах үе шат, цаглабраар[1] хэрэгжүүлнэ. Үүнд:

| Үе шат | Хэрэгжүүлэх процесс | Хугацаа |
|---|---|---|
| 1-р үе шат: Төслийг үнэлэх | Төсвийн ерөнхийлөн захирагч Аргачлал 2-ын дагуу хийгдсэн шинжилгээнд үндэслэн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч шинээр хэрэгжүүлэх төслүүдийг тодорхойлж, жагсаалтыг Сангийн яаманд хүргүүлнэ. | Жил бүрийн 06 дугаар сарын 01-ний дотор |
| | Сангийн яам ирүүлсэн төслүүдийн үнэлгээний оноог хянаж, шаардлагатай тохиолдолд оноог засварлаж, хэрэгжүүлэх боломжтой төслүүдийн жагсаалтыг төсвийн удирдамжийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагч нарт хүргүүлнэ. | Жил бүрийн 07 дугаар сарын 05-ны дотор |
| 2-р үе шат: Төслийг эрэмбэлэх, сонгох | Төсвийн ерөнхийлөн захирагч Сангийн яамнаас ирүүлсэн төслийн жагсаалтад орсон төслүүдийг сонгох шалгуур үзүүлэлтийн дагуу оноо өгч эрэмбэлэн, төсвийн төсөлд тусгах саналаа Сангийн яаманд хүргүүлнэ. | Жил бүрийн 08 дугаар сарын 15-ны дотор |
| | Сангийн яам ирүүлсэн төслүүдийн сонгох шалгуур үзүүлэлтийн оноог хянаж, шаардлагатай тохиолдолд оноог засварлан эрэмбэлж төсвийн төсөлд тусгах нэгдсэн жагсаалтыг боловсруулна. | Жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны дотор |

2.2. Төслийг үнэлэх 1-р үе шатанд төслийг Аргачлал 2-т заасан шинжилгээний үр дүнд тулгуурлан дараах 7 шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

2.2.1. бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;

[1] Ерөнхий загварыг Аргачлалын хавсралтын Хүснэгт №1-ээр оруулав.

2.2.2. бусад төсөл, хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой эсэх;
2.2.3. эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол;
2.2.4. төслийн хүчин чадлын ашиглалт;
2.2.5. төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх;
2.2.6. төслийн болзошгүй эрсдэл;
2.2.7. төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх.

2.3. Төслийг сонгох 2-р үе шатанд Сангийн яамнаас төсвийн төсөлд тусгах боломжтой болохыг нь 1-р үе шатны үнэлгээгээр тодорхойлсон төслүүдээс дараах 9 шалгуур үзүүлэлтээр үнэлж, сонголтыг хийнэ. Үүнд:
2.3.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал;
2.3.2. тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд нийцэж буй байдал;
2.3.3. тухайн жилийн үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;
2.3.4. төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;
2.3.5. санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл;
2.3.6. урсгал зардлыг тогтвортой санхүүжүүлэх боломжтой эсэх, төсөвт үзүүлэх ачаалал;
2.3.7. төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл;
2.3.8. төслийг хэрэгжүүлэх бусад нөхцөл бүрдсэн эсэх;
2.3.9. төсвийн ерөнхийлөн захирагчийн эрэмбэлсэн байдал.

2.4. Төслийг эрэмбэлэх, сонгох 2-р үе шатанд зөвхөн эрх бүхий байгууллагаас олгосон газрын зөвшөөрөлтэй, тухайн газар нь чөлөөлөгдсөн болон барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийлгэж, дүгнэлт гаргуулсан төслүүдийг оруулж үнэлнэ.

2.5. Энэхүү аргачлалын 2.2 болон 2.3-т заасан ангиллын шалгуур үзүүлэлт бүр нь тус тус 5 асуулгатай байх ба төслийг үнэлэхдээ тухайн шалгуур үзүүлэлтийг хэрхэн хангаж байгааг Аргачлалын хавсралт дах Хүснэгт №2 – №3-т заасан тохирох хариултыг сонгосноор оноо өгөгдөнө.

2.6. Төслийн үнэлгээний 1-р үе шатны шалгуур үзүүлэлт тус бүрийн оноо нь төслийн стратегийн ач холбогдол, эрэлт хэрэгцээ, эдийн засгийн үнэ цэнэ, санхүүгийн үндэслэл, болзошгүй эрсдэлийг үнэлнэ.

2.7. Төслийг сонгох 2-р үе шатны шалгуур үзүүлэлт тус бүрийн оноо нь төслийн бэлэн байдал, богино хугацааны хөгжлийн бодлого, чиглэлтэй нийцэж буй байдал, улсын төсөвт нөлөөлөх ачаалал, төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэлийг хянаж удирдах, төсөл хэрэгжүүлэх нөхцөлийг хангаж буй эсэхийг үнэлнэ.

2.8. Төслийн үнэлгээг Цахим системд оруулсан төслийн дэлгэрэнгүй мэдээлэл, нотлох баримт бичигт үндэслэн гүйцэтгэнэ.

## Гурав. Төслийг үнэлж, оноо өгөх процесс

3.1. Төслийг үнэлэх 1-р үе шат болон төслийг сонгох 2-р үе шатанд төслийг үнэлж, оноо өгөх процесс нь Цахим системийн үнэлгээний матрицаар хийгдэнэ.

3.2. Цахим системд Аргачлалын 2.2 болон 2.3-т заасан ангилал болон шалгуур үзүүлэлтүүд, түүнд хамаарах оноо өгөх асуулга, ач холбогдлыг нь харгалзан 1 – 3 дахин нэмэгдүүлэх тогтмол жинг Сангийн яамнаас оруулсан байна.

3.3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд төслийг Цахим системийн холбогдох цэсэд дараах байдлаар үнэлж, оноо өгнө. Үүнд:

| Төсвийн ерөнхийлөн захирагчийн төслийг үнэлж, оноо өгөх ажиллагаа | | |
|---|---|---|
| Хариуцах этгээд, чиг үүрэг | | Хийгдэх ажиллагаа |
| **Хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн** | Мэргэжилтэн тухайн төсөл нь үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрийг хэрхэн хангаж буйг харгалзах оноо бүхий 5 асуулгаас сонгож төсөлд оноогоор үнэлгээ өгнө. | 1/ Аргачлал 2-ын дагуу хийсэн төслийн шинжилгээний үр дүн, тооцоолол, үндэслэл, дэлгэрэнгүй мэдээлэл, тэдгээрийг нотлох баримт бичгүүдийг Цахим системийн холбогдох цэсээр оруулж, файлыг хавсаргасан байна. |
| | | 2/ Тухайн санхүүгийн жилд шинээр эхлэх төслүүдийн жагсаалт Цахим системийн "төслийг үнэлэх, сонгох" цэсэд гарч ирсэн байх ба төсөл тус бүрээр үнэлж оноо өгнө. |
| **Ажлын хэсэг** | Мэргэжилтний үнэлж эрэмбэлсэн төслүүдийг төсөл тус бүрээр хэлэлцэх ба шаардлагатай тохиолдолд засварлаж, төсөвт тусгах төслүүдийн талаар нэгдсэн шийдвэр гаргана. | 1/ Цахим системд хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний оруулсан төслийн мэдээлэлтэй танилцсан байна. |
| | | 2/ Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний онооны үнэлгээний тайлбар тайланг сонсож хэлэлцэнэ. |
| | | 3/ Төслийг хэлэлцэх явцад гарсан асуулт, тодруулга, тайлбарын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, нэгдсэн шийдвэрийн хамт баталгаажуулсан байна. |

3.4. Сангийн яамны түвшинд төслийг цахим системийн холбогдох цэсэд дараах байдлаар үнэлж, оноо өгнө. Үүнд:

| Сангийн яамны түвшинд хийгдэх төслийг үнэлж, оноо өгөх ажиллагаа | | |
|---|---|---|
| Хариуцах этгээд, чиг үүрэг | | Хийгдэх ажиллагаа |
| **Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж** | Төсвийн ерөнхийлөн захирагчдын үнэлж эрэмбэлэн ирүүлсэн төслийн багцыг хариуцсан мэргэжилтэн хянаж шаардлагатай тохиолдолд төслийн оноог засварлана. | 1/ Цахим системд Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтний оруулсан төслийн мэдээлэлтэй танилцсан байна. |
| | | 2/ Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ажлын хэсгийн төсөл хэлэлцсэн дэлгэрэнгүй тэмдэглэл, шийдвэртэй танилцсан байна. |
| | | 3/ Цахим системийн "төслийг үнэлэх, сонгох" цэсэд гарч ирсэн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөл тус бүрийн үнэлгээний оноог хянаж, өөрчлөх тохиолдолд Сангийн яамны оноо гэсэн цонхонд оноог засварлана. |
| **Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга** | Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн нэгтгэн гаргасан төслүүдийг хянаж хэлэлцээд шаардлагатай тохиолдолд төслийн оноог завсарлаж, эцсийн үнэлгээг гаргана. | 1/ Төсвийн ерөнхийлөн захирагчийн Ажлын хэсгийн төсөл хэлэлцсэн дэлгэрэнгүй тэмдэглэл, шийдвэртэй танилцсан байна. |
| | | 2/ Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн онооны үнэлгээний тайлбар, тайланг хэлэлцэнэ. |
| | | 3/ Төслийг хэлэлцэх явцад гарсан асуулт, тодруулга, тайлбарын дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, нэгдсэн шийдвэрийн хамт баталгаажуулсан байна. |

3.5. Төсвийн ерөнхийлөн захирагчийн түвшинд Ажлын хэсэг, Сангийн яамны түвшинд Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын хүлээн зөвшөөрсөн төслийн шалгуур үзүүлэлтүүдийн оноо нь Сангийн яамны оруулсан харгалзах тогтмол жингээр үржигдэн гарснаар төслийн нийт эцсийн оноо тодорхойлогдоно.

3.6. Төслүүдэд өгсөн онооны үр дүнг буюу төслүүдийн эрэмбийг Цахим систем нь дүрст графикаар гаргана. Ерөнхий дүрслэл болон тайлбарыг холбогдох гарын авлагаас тодруулж үйл ажиллагаандаа ашиглана.

3.7. Шинээр хэрэгжүүлэх бэлтгэл бүрэн хангагдаагүй, нэмэлт үйл ажиллагаа шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлэх хугацааг хойшлуулан Цахим системд үлдээх ба хэрэгжүүлэх шаардлагагүй гэсэн дүгнэлт гарсан төслүүдийг Цахим системийн тусгай цэсэд хадгална.
3.8. Төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яамны хүрээнд үнэлэгдсэн төслүүдийг Цахим системийн "төслийн үнэлгээ, сонголт" цэсээс файлаар болон хэвлэн авах боломжтой.

## Дөрөв. Төслүүдийг эрэмбэлэх, сонгох зарчим

4.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь Цахим системийн "төлөвлөгөө/төсөв" цэсээр орж үнэлэгдсэн төслүүдээс сонгож багц үүсгэн Сангийн яаманд цахимаар илгээхээс гадна Аргачлалын 3.8-д дурдсан жагсаалтыг хэвлэн гаргаж Ажлын хэсгийн дэлгэрэнгүй тэмдэглэлийн хамт Сангийн яаманд албан ёсоор хүргүүлнэ.
4.2. Төслийг үнэлэх 1-р үе шатанд өгөгдсөн нийт оноо болон төслийг эрэмбэлэх, сонгох 2-р үе шатанд өгөгдсөн нийт онооны нийлбэрээр тухайн төслийн эцсийн оноо тодорхойлогдоно.
4.3. Эрэмбэлэлтийн дараалалд дараах нөхцөл байдлаас бусад тохиолдолд хамгийн өндөр оноо авсан төслийг эхний ээлжид хэрэгжүүлэхээр төсвийн хязгаарт багтаан сонгоно:
    4.3.1. давагдашгүй хүчин зүйлийн (гал түймэр, газар хөдлөлт, осол гарсан зэрэг) улмаас Улсын Их Хурал болон Засгийн газраас зайлшгүй хэрэгжүүлэхээр шийдвэр гарсан төслүүд;
    4.3.2. нягт уялдаа холбоо бүхий иж бүрнээр нь ашиглалтад оруулах төслүүд.

**Хүснэгт 1: Төслийг шалгуур үзүүлэлтээр үнэлж, оноо өгөх ерөнхий загвар**

| Үе шат | | Шалгуур үзүүлэлт | Төсвийн ерөнхийлөн захирагч | | | Сангийн яам | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Оноо | Жин | Дүн | Оноо | Жин | Дүн |
| Төслийн үнэлгээ хийх | 1-1 | Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал | 5 | 1.5 | 7.5 | 5 | 1.5 | 7.5 |
| | 1-2 | Бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой эсэх | 5 | 2.5 | 12.5 | 5 | 2.5 | 12.5 |
| | 1-3 | Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол | 5 | 3 | 15 | 5 | 3 | 15 |
| | 1-4 | Төслийн хүчин чадлын ашиглалт | 5 | 2.5 | 12.5 | 5 | 2.5 | 12.5 |
| | 1-5 | Төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх | 5 | 3 | 15 | 5 | 3 | 15 |
| | 1-6 | Төслийн болзошгүй эрсдэл | 5 | 2 | 10 | 5 | 2 | 10 |
| | 1-7 | Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх | 5 | 2 | 10 | 5 | 2 | 10 |
| | | **Дүн:** | | | 82.5 | | | 82.5 |
| Төслийг эрэмбэлэх, сонгох | 2-1 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал | 5 | 1 | 5 | 5 | 1 | 5 |
| | 2-2 | Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд нийцэж буй байдал | 5 | 1 | 5 | 5 | 1 | 5 |
| | 2-3 | Тухайн жилийн үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал | 5 | 1 | 5 | 5 | 1 | 5 |
| | 2-4 | Төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх | 5 | 3 | 15 | 5 | 3 | 15 |
| | 2-5 | Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл | 5 | 1.5 | 7.5 | 5 | 1.5 | 7.5 |
| | 2-6 | Урсгал зардлыг тогтвортой санхүүжүүлэх боломжтой эсэх, төсөвт өгөх ачаалал | 5 | 1 | 5 | 5 | 1 | 5 |
| | 2-7 | Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл | 5 | 2.5 | 12.5 | 5 | 2.5 | 12.5 |
| | 2-8 | Төслийг хэрэгжүүлэх бусад нөхцөл бүрдсэн эсэх | 5 | 1.5 | 7.5 | 5 | 1.5 | 7.5 |
| | 2-9 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрэмбэлсэн байдал | 5 | 1 | 5 | 5 | 1 | 5 |
| | | **Дүн:** | | | 67.5 | | | 67.5 |

**Тайлбар:** Оноог 1-5-ын хооронд өгөх боломжтой, ач холбогдлын жин нь тогтмол байна.

### Хүснэгт 2: Төслийн үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

| | Шалгуур үзүүлэлт | Асуулга | Харгалзах оноо |
|---|---|---|---|
| 1-1. | Бодлогын баримт бичигт тусгагдсан байдал | • Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгагдсан; | 1 оноо |
| | | • Бүсчилсэн хөгжлийн бодлогод тусгагдсан; | 2 оноо |
| | | • Орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдсан; | 3 оноо |
| | | • Улсын Их Хурал болон Засгийн газрын шийдвэртэй; | 4 оноо |
| | | • Салбарын хөгжлийн бодлогод онцгойлон тусгагдсан; | 5 оноо |
| 1-2. | Бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилттэй холбоотой эсэх | • Салбар дундын хөгжлийн тэнцвэрийг хангах ач холбогдолтой; | 1 оноо |
| | | • Бусад төслийн хэрэгжилтийн бэлтгэл болно; | 2 оноо |
| | | • Хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд тодорхой хэмжээгээр нөлөөлнө; | 3 оноо |
| | | • Хэрэгжиж байгаа бусад төсөл хөтөлбөрийн хэрэгжилтэд шууд нөлөөлнө; | 4 оноо |
| | | • Онц чухал төслийн хэрэгжилтэд шууд нөлөөлнө; | 5 оноо |
| 1-3 | Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол | • Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол тодорхой бус; | 1 оноо |
| | | • Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол хязгаарлагдмал; | 2 оноо |
| | | • Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол дунд зэрэг; | 3 оноо |
| | | • Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол өндөр; | 4 оноо |
| | | • Эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол маш өндөр; | 5 оноо |
| 1-4 | Төслийн хүчин чадлын ашиглалт | • 5 дах жилээс хойш; | 1 оноо |
| | | • 4 дэх жилдээ; | 2 оноо |
| | | • 3 дах жилдээ; | 3 оноо |
| | | • 2 дах жилдээ; | 4 оноо |
| | | • Эхний жилдээ; | 5 оноо |
| 1-5 | Төслийн зардлыг бүрэн тооцсон эсэх | • Төслийн өртгийг 2-оос дээш жилийн өмнө тооцсон; | 1 оноо |
| | | • Барилга байгууламжийн төсөвт өртөг тооцогдсон; | 2 оноо |
| | | • Төслийн бэлтгэл ажлын зардал, газар, барилга байгууламжийн төсөвт өртөг тооцогдсон; | 3 оноо |
| | | • Төслийн бэлтгэл ажлын зардал, газар, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн өртөг тооцогдсон; | 4 оноо |
| | | • Төслийн бэлтгэл ажлын зардал, газар, барилга байгууламж, угсрагдахгүй тоног төхөөрөмж, урсгал зардал тооцогдсон; | 5 оноо |
| 1-6 | Төслийн болзошгүй эрсдэл | • Тодорхой бус; | 1 оноо |
| | | • Төслийн зорилт төдийлөн тодорхой бус, үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлал өндөр | 2 оноо |
| | | • Төслийн зорилт нь зарим байдлаар тодорхой ч хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлалтай; | 3 оноо |

| | Шалгуур үзүүлэлт | Асуулга | Харгалзах оноо |
|---|---|---|---|
| | | • Төслийн зорилт нь тодорхой хэдий ч хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлал тодорхой хэмжээгээр байгаа;<br>• Төслийн зорилт нь маш тодорхой бөгөөд, хэрэгжүүлэх явцад үйл ажиллагааны төлөвлөгөө өөрчлөгдөх магадлал тун бага; | 4 оноо<br>5 оноо |
| 1-7 | Төсөл хэрэгжсэний дараа үйл ажиллагааг нь үр ашигтай тогтвортой удирдах туршлага, чадавх байгаа эсэх | • Мэргэжилтэй боловсон хүчин тусгайлан бэлтгэнэ;<br>• Гадаадаас мэргэжилтэн урьж ажиллуулна;<br>• Ажлын байранд дадлагажуулна;<br>• Мэргэжлийн ажиллагсад зах зээлд олдоцтой;<br>• Ижил төстэй үйл ажиллагаа хэрэгжүүлж байсан мэргэжилтэй боловсон хүчин бэлэн. | 1 оноо<br>2 оноо<br>3 оноо<br>4 оноо<br>5 оноо |

## Хүснэгт 3: Төслийг сонгох шалгуур үзүүлэлт

| | Шалгуур үзүүлэлт | Асуулга | Харгалзах оноо |
|---|---|---|---|
| 2-1 | Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан байдал | • Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй; | 1 оноо |
| | | • Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ерөнхий байдлаар тусгагдсан; | 2 оноо |
| | | • Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тодорхой тусгагдсан; | 3 оноо |
| | | • Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2-оос дээш заалтыг хангана; | 4 оноо |
| | | • Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тэргүүлэх ач холбогдолтойгоор тодорхой тусгагдсан; | 5 оноо |
| 2-2 | Тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд нийцэж буй байдал | • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд тусгагдаагүй; | 1 оноо |
| | | • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлтэй шинж чанарын хувьд нийцэж буй; | 2 оноо |
| | | • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлтэй нийцэж буй; | 3 оноо |
| | | • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогод нийцэж байгаа тэргүүлэх ач холбогдолтой; | 4 оноо |
| | | • Улсын төсвийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэлд тэргүүлэх ач холбогдолтойгоор тодорхой тусгагдсан; | 5 оноо |
| 2-3 | Тухайн жилийн үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал | • Үндсэн чиглэлд тусгагдаагүй | 1 оноо |
| | | • Үндсэн чиглэлд ерөнхий байдлаар тусгагдсан; | 2 оноо |
| | | • Үндсэн чиглэлд тодорхой тусгагдсан; | 3 оноо |
| | | • Үндсэн чиглэлийн 2-оос дээш чиглэлийг хангана; | 4 оноо |
| | | • Үндсэн чиглэлд тэргүүлэх ач холбогдолтойгоор тодорхой тусгагдсан; | 5 оноо |
| 2-4 | Төслийн зардлыг бүрэн, зөв тооцсон эсэх | • Нэг маягийн зураг төсөв, жишиг үнэлгээгээр тооцоолсон; | 1 оноо |
| | | • Төслийн зардалд тодорхой ажлууд дутуу тооцогдсон; | 2 оноо |
| | | • Төслийн зардал өнөөгийн бодит зах зээлийн үнээс 20-оос дээш хувиар зөрүүтэй; | 3 оноо |
| | | • Төслийн зардал өнөөгийн бодит зах зээлийн үнээс 20 хүртэл хувиар зөрүүтэй; | 4 оноо |
| | | • Төслийн зардал өнөөгийн үнээр бүрэн тооцогдсон; | 5 оноо |
| 2-5 | Санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл | • Хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс 100% санхүүжүүлнэ; | 1 оноо |
| | | • Бусад эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудал хэлэлцээрийн шатанд байна; | 2 оноо |
| | | • Хөрөнгө оруулалтын зардлын 25 хүртэл хувийг хамтран санхүүжүүлэх эх үүсвэр баталгаажсан; | 3 оноо |
| | | • Хөрөнгө оруулалтын зардлын 50-аас дээш хувийг хамтран санхүүжүүлэх эх үүсвэр баталгаажсан; | 4 оноо |

| | Шалгуур үзүүлэлт | Асуулга | Харгалзах оноо |
|---|---|---|---|
| | | • Хөрөнгө оруулалтын зардлын 75-аас дээш хувийг хамтран санхүүжүүлэх эх үүсвэр баталгаажсан; | 5 оноо |
| 2-6 | Урсгал зардлыг тогтвортой санхүүжүүлэх боломжтой эсэх, төсөвт үзүүлэх ачаалал | • Урсгал зардал нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгагдаагүй. | 1 оноо |
| | | • Урсгал зардлыг улсын төсвөөс бүрэн санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгасан; | 2 оноо |
| | | • Урсгал зардлын 60 хүртэлх хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгасан; | 3 оноо |
| | | • Урсгал зардлын 30 хүртэлх хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тооцоололд тусгасан; | 4 оноо |
| | | • Урсгал зардлыг өөрийн орлогоор тогтвортой санхүүжүүлэх боломжтой; | 5 оноо |
| 2-7 | Төсөл хэрэгжүүлэх явцад гарч болзошгүй эрсдэл | • Эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй; | 1 оноо |
| | | • Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл өндөр; | 2 оноо |
| | | • Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл дунд зэрэг; | 3 оноо |
| | | • Эрсдэлийн хүчин зүйлийн нөлөөлөл бага; | 4 оноо |
| | | • Эрсдэлийн хүчин зүйлийг хянаж зохицуулах боломжтой; | 5 оноо |
| 2-8 | Төсөл хэрэгжүүлэх бусад нөхцөл бүрдсэн эсэх | • Нэмэлт үйл ажиллагаа, зохицуулалт шаардлагатай; | 1 оноо |
| | | • Зарим бэлтгэл үйл ажиллагаа дутуу боловч хэрэгжүүлэх явцад тэдгээр нөхцөлүүдийг бүрдүүлэх боломжтой; | 2 оноо |
| | | • Шаардлагатай үндэслэл, зөвшөөрөл зэргийн тодорхой хэсэг нь хангалттай бус боловч, хэрэгжүүлж эхлэхийн өмнө бүрэн хангах боломжтой; | 3 оноо |
| | | • Үлдсэн 1-2 асуудал шийдвэрлэгдэх шатандаа байгаа; | 4 оноо |
| | | • Төслийг хэрэгжүүлж эхлэх бэлтгэл бүрэн хангагдсан; | 5 оноо |
| 2-9 | Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрэмбэлсэн байдал | • Хойшлуулж болох; | 1 оноо |
| | | • Шаардлагатай; | 2 оноо |
| | | • Чухал ач холбогдолтой; | 3 оноо |
| | | • Улсын Их хурал болон Засгийн газрын шийдвэртэй; | 4 оноо |
| | | • Нэн чухал ач холбогдолтой. | 5 оноо |

МОНГОЛ УЛСЫН

# САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 25 өдөр Дугаар 282 Улаанбаатар хот

## Журам шинэчлэн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Батлагдсан журмыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах үйл ажиллагаанд мөрдөж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, журмын биелэлтийг хангаж ажиллахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/, Төрийн сангийн газар /М.Батхуяг/-т тус тус үүрэг болгосугай.

3. Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн ил тод байдлыг энэхүү журам батлагдсанаас хойш журамд заасны дагуу цахим системд тусгаж хэрэгжүүлэхийг бүх шатны Төсвийн ерөнхийлөн захирагчид, аймаг, нийслэлийн Засаг дарга нар болон Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн хөрөнгө оруулалтын газар /Г.Түвдэндорж/, Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Доржсэмбэд/-т тус тус үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам" болон Сангийн сайдын 2017 оны "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" 273 дугаар тушаалыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус хүчингүй болгосонд тооцсугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

976678

Сангийн сайдын 2019 оны
12 дугаар сарын 25-ны өдрийн
282 тоот тушаалын хавсралт

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨХ, САНХҮҮЖҮҮЛЭХ, ХЯНАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
## Нийтлэг үндэслэл

**Нэг. Зорилго, хамрах хүрээ**

1.1 Энэхүү журмын зорилго нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт болон санхүүжилтийн удирдлагыг боловсронгуй болгох замаар төсвийн зардлыг бууруулж, төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд оршино.

1.2 Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээ зэрэг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.3 Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй аливаа хөрөнгө оруулалт, концессын гэрээний эргэн төлөлт, улсын төсвийн бүрэлдэхүүнд ордог Засгийн газрын тусгай сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламж, тоног төхөөрөмж, их засвар, бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх, хяналт тавих, тайлагнахад энэ журмыг мөрдлөг болгоно.

1.4 Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын (цаашид “Сангийн яам” гэх) төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж энэхүү журмын хэрэгжилт, зохион байгуулалтыг хангаж ажиллана.

**Хоёр. Хууль тогтоомж**

2.1 Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Барилгын тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, Концессын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөлтөд Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан дараах журам, аргачлалыг удирдлага болгоно. Үүнд:

2.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам;

2.2.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төслийг дахин үнэлэх аргачлал;

2.2.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал;

2.2.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал.

2.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын систем (цаашид “Цахим систем” гэх) гэдэгт төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх,

хяналт тавих, мэдээллийг хадгалах зориулалт бүхий цахим системийг ойлгоно.

2.4 Энэхүү журамд дурдсан нэр томьёог холбогдох хууль тогтоомжид заасны дагуу тодорхойлж, тайлбарлана.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ
## Эрх бүхий байгууллагын чиг үүрэг

### Гурав. Эрх бүхий байгууллагын чиг үүрэг

3.1 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ /цаашид “төсөл, арга хэмжээ” гэх/-ний төлөвлөлт, төсөвлөлт, санхүүжилтийн удирдлагыг хариуцан ажиллах бөгөөд энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.1.1 төсөл, арга хэмжээний саналыг энэ журамд зааснаар хүлээн авах, нэгтгэх, төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, хяналтыг хэрэгжүүлэх;

3.1.2 төсөл, арга хэмжээний төсвийн эрсдэлийн шинжилгээг хийх, тухайн төслийн санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр болон улсын төсөвт учруулж болох дарамт, нөлөөллийг тооцож, дүгнэлт гаргах;

3.1.3 төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэн төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулах;

3.1.4 дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон жилийн төсвийн хязгаарт багтаан төсөл, арга хэмжээний нийт саналыг боловсруулах;

3.1.5 улсын төсвийн хөрөнгө оруулалтын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж ажиллах;

3.1.6 хууль, журмын шаардлага хангасан төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн санхүүжилтийн эрхийг нээх;

3.1.7 хууль, журмын шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохгүй байх;

3.1.8 энэ журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай баримт, материал, мэдээллийг төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн байгууллага, холбогдох бусад этгээдээс гаргуулж авах;

3.1.9 төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, үр ашиг, үр дүнг тооцох аргачлал, үнэлгээний тайлангийн загварыг боловсруулж, хэрэгжүүлэх;

3.1.10 Цахим системийн удирдлагыг хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах;

3.1.11 улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, сургалт хэлэлцүүлэг зохион байгуулах;

3.1.12 улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилттэй танилцах, түүний мөрөөр холбогдох арга хэмжээ авах.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1 төсөл, арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх;

3.2.2 төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач

холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах;

3.2.3 энэ журамд зааснаар үнэлж, эрэмбэлсний дагуу тухайн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг улсын төсөвт тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлэх;

3.2.4 улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байх;

3.2.5 энэ журамд заасан аргачлал, заавар, гарын авлагыг үйл ажиллагаандаа мөрдөж, хэрэгжилтийг хангах;

3.2.6 төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хууль, журмын хүрээнд зохион байгуулж, хангах;

3.2.7 улсын төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр тухайн салбарын судалгаа, дүн шинжилгээ хийх, танилцуулга, мэдээлэл бэлтгэх;

3.2.8 улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийг Цахим системээр дамжуулан гүйцэтгэх;

3.2.9 улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлэх, санхүүжилтийг олгох;

3.2.10 улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн материалыг хууль, журамд нийцүүлэн бүрэн, үнэн зөв бүрдүүлэх.

3.3 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилт, хэрэгжилт, гүйцэтгэлийн үйл ажиллагаа, үр дүнг хариуцаж ажиллана.

3.4 Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад тухайн жилд батлагдсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.5 Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилд хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ тус бүрт хамаарах гэрээний хуулбарыг (барилга угсралт, их засварын ажлын тухайд үе шатны хуваарь, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан худалдан авах ажиллагааны материалын хамт) уг гэрээг байгуулснаас хойш ажлын 5 хоногт багтаан Сангийн яаманд хүргүүлнэ.

3.6 Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 3.5-д зааснаар холбогдох гэрээг Сангийн яаманд хүргүүлэхдээ Цахим системд гэрээг бүртгэж, хуубар файлыг оруулсан байна.

3.7 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад бөөн дүнгээр батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний задаргааг холбогдох шийдвэрийн хамт Сангийн яаманд ажлын 5 хоногт багтаан хүргүүлнэ.

3.8 Төсвийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын үе шатуудад холбогдох мэдээлэл, баримт бичгийн иж бүрдлийг Цахим системд оруулж, албан бичгээр баталгаажуулан Сангийн яаманд хүргүүлэх бөгөөд тэдгээрийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангаж ажиллана.

**Дөрөв. Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг шилжүүлэх**

4.1. Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг дараах байдлаар шилжүүлж болно. Үүнд:

4.1.1. Төсвийн тухай хуулийн 14.4-т заасныг үндэслэн Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн төвлөрүүлэн захирагчид, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих эрхийг шилжүүлэх;
4.1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.6-д заасны дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг шилжүүлэх;
4.1.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх эрхийг Төсвийн тухай хуулийн 14, 61 дүгээр зүйлийг үндэслэн аймаг, нийслэлийн Засаг даргад шилжүүлэх.

4.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нь эрх шилжүүлэх тохиолдолд шийдвэрийг тухайн жилийн 2 дугаар сарын 1-ний дотор гаргаж, ажлын 3-5 хоногт багтаан Сангийн яаманд хүргүүлнэ.
4.3. Эрх шилжүүлэн авсан этгээд нь тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд энэ журамд заасныг удирдлага болгон ажиллана.
4.4. Эрх шилжүүлсэн этгээд нь тухайн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагналт, үр дүн, гүйцэтгэлд эрх бүхий этгээдийн хувиар хариуцлага хүлээнэ.

**Тав. Захиалагчийн чиг үүрэг**

5.1 Энэхүү журмын хүрээнд дараах этгээд нь захиалагч байна. Үүнд:
5.1.1 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан Төсвийн захирагч;
5.1.2 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45.2-т заасан этгээд.

5.2 Захиалагч нь энэхүү журмын хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:
5.2.1 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг барилга байгууламжийн болон норм, нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж, хянан баталгаажуулах;
5.2.2 санхүүжилтийн гүйцэтгэлийн материалыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх олгосон шийдвэрийн дагуу Төсвийн шууд захирагч, эсхүл санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын гарын үсгээр хянан баталгаажуулж, албан бичгээр болон Цахим системээр дамжуулан Сангийн яаманд хүргүүлэх;
5.2.3 барилга байгууламж, их засварын ажил, зөвлөх үйлчилгээ, концессын гэрээний эргэн төлөлт зэрэг төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг энэ журамд зааснаар үнэн зөв гаргаж, холбогдох маягтын дагуу ирүүлэх;
5.2.4 төсөл, арга хэмжээний санхүүжилтийг энэ журамд зааснаар гүйцэтгэгч байгууллагад олгох, гүйцэтгэлийн санхүүжилтийг үндэслэлгүйгээр саатуулахгүй байх;
5.2.5 барилга байгууламж, өргөтгөл, их засварын ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар холбогдох дүрмийн дагуу ашиглалтад хүлээн авсны үндсэн дээр эцсийн санхүүжилт хүсэх;
5.2.6 барилгын ажлын зардал, техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа /цаашид “ТЭЗУС” гэх/, техник, эдийн засгийн үндэслэл /цаашид “ТЭЗҮ” гэх/, зураг төслийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, нормчлолын сангийн зардал, чанарын баталгаат

хугацааны барьцааг тус тусын дансанд холбогдох баримт, материал, тоног төхөөрөмж хүлээн авсан акт зэргийг үндэслэн шилжүүлэх;

5.2.7 төсөл, арга хэмжээний санхүүжилт хүссэн гүйцэтгэлд ирүүлж буй холбогдох баримт, материал, мэдээллүүдийн иж бүрдэл, үнэн зөв эсэхэд бүрэн хариуцлага хүлээнэ.

5.3 Захиалагч нь төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдсан болохыг баталгаажуулсан тодорхойлолтыг гүйцэтгэлийн материалд хавсарган Сангийн яаманд хүргүүлнэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ
## Төсөл, арга хэмжээний төлөвлөлт, тавигдах шаардлага

### Зургаа. Төсөл, арга хэмжээний төлөвлөлт

6.1. Төсөл, арга хэмжээг сонгох, төлөвлөх харилцааг энэ журмын 2.2-т заасан журам болон аргачлалд зааснаар зохицуулна.

6.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төслүүд нь төсвийн хөрөнгө оруулалтаар зайлшгүй санхүүжүүлэх шаардлагатай нь холбогдох нотлох баримтаар тогтоогдсон төсөл байх бөгөөд энэ журамд зааснаар төлөвлөнө.

6.3. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 6.2-т заасан төсөл, арга хэмжээг төсөвт тусгуулах саналыг албан бичгээр болон Цахим системээр дамжуулан Төсвийн тухай хуульд заасан төсвийн цаглабарын дагуу Сангийн яаманд хүргүүлнэ.

6.4. Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 6.2-т заасан төсөл, арга хэмжээний саналыг ирүүлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэхийг судалж, холбогдох тайлан болон материалыг хавсаргасан байна:

6.4.1. бодлогын баримт бичигт тусгагдсан байдал;

6.4.2. тухайн жилийн хөрөнгө оруулалтын бодлогын чиглэл болон үндсэн чиглэлтэй нийцэж буй байдал;

6.4.3. хэрэгцээ шаардлага, үндэслэл;

6.4.4. мэргэжлийн байгууллагын дүгнэлт;

6.4.5. төслийн зардлыг бүрэн зөв тооцсон эсэх;

6.4.6. санхүүжилтийн эх үүсвэрийн төрөл.

6.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх нийт төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний саналыг энэхүү журмын Хавсралт №1-д заасан маягтын дагуу Цахим системд мэдээллийг бүрэн оруулж боловсруулна.

6.6. Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг энэ журамд заасныг баримтлан гүйцэтгээгүй, шаардлагатай баримт бичгийн иж бүрдэл, материал, мэдээллийг албан бичгээр болон Цахим системээр ирүүлээгүй тохиолдолд хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд тусгахгүй байх үндэслэл болно.

6.7. Төсвийн ерөнхийлөн захирагч болон концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь төсвийн хөрөнгө оруулалтаар эргэн төлөлт хийгдэх концессын төслийн санал, тооцоог гаргаж, холбогдох бусад материалын хамт хуульд заасан хугацаанд Сангийн яаманд цахимаар болон албан бичгээр ирүүлнэ.

### Долоо. Төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлага

7.1. Төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төсөл, арга хэмжээ нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид

заасан шаардлагад нийцсэн, холбогдох Аргачлалд заасны дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлэгдсэн, эдийн засгийн үр ашигтай, нийгмийн ач холбогдолтой, тэргүүлэх зэрэглэлийн төслүүд байна.

7.2. Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нь дараах шаардлагыг хангасан байх бөгөөд уг шаардлагыг хангаагүй төслийг төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгахгүй. Үүнд:

7.2.1. эрх бүхий байгууллагаас газрын болон бусад шаардлагатай зөвшөөрлийг авсан байх;

7.2.2. барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

7.2.3. шаардлагатай тохиолдолд төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, ТЭЗУС-ыг хийлгэсэн байх.

7.3. Их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний төсөл, арга хэмжээнд дараах шаардлагыг тавина:

7.3.1. шаардлагатай тохиолдолд урсгал зардлыг тооцсон байх;

7.3.2. төсвийн хязгаарт багтсан, нэн тэргүүний ач холбогдолтой байх;

7.3.3. холбогдох материал, нотлох баримтаар баталгаажсан, төлөвлөлт, зорилтод нийцсэн, хэрэгцээ шаардлагад тулгуурласан байх;

7.3.4. тухайн барилга байгууламжийн ашиглалт, норм, хугацаа, элэгдлийн байдал, мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, засварын хөрөнгийн төсөв, холбогдох материалд үндэслэсэн байх.

7.4. ТЭЗУС, ТЭЗҮ боловсруулах төсөл, арга хэмжээ болон зөвлөх үйлчилгээний ажил нь холбогдох хууль тогтоомжид үндэслэсэн, тухайн байгууллага, эсхүл салбарын зорилт болон дунд хугацааны төлөвлөлтөд нийцсэн, байгууллагын эрэлт хэрэгцээ, бодит шаардлагад тулгуурласан байна.

**Найм. Төсөл, арга хэмжээг улсын төсөвт тусгах**

8.1. Сангийн яам, Төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ журмын 2.2.1-д заасан журмыг баримтлан төсвийн төсөлд тусгах төслийг сонгох болон төслийн санхүүжилтийг шийдвэрлэхдээ дараах эрэмбийг баримтална. Үүнд:

8.1.1. шилжих буюу хэрэгжүүлж буй төсөл;

8.1.2. их засварын төсөл;

8.1.3. шинээр хэрэгжүүлэх төсөл.

8.2. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь нийт төсөл, арга хэмжээний жагсаалтыг энэ журмын 2.2-т заасан журам, аргачлалыг үндэслэн боловсруулах ба тухайн жилийн төсвийн хязгаарыг үндэслэн эрэмбийн дагуу төсвийн төсөлд тусгана.

8.3. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, тухайн жилийн төсвийн хязгаар, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлага, шалгуур үзүүлэлтэд нийцэж байгаа эсэхийг хянаж, судалсны дагуу төсвийн төсөлд тусгах шийдвэрийг гаргана.

8.4. Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь төсвийн хөрөнгө оруулалтын төслийг төсөвт тусгахдаа дараах журмыг баримтална. Үүнд:

8.4.1. нэг жилийн дотор хэрэгжиж дуусах богино хугацааны хөрөнгийн урсгал засвар, хөрөнгийн шинэчлэл, тоног төхөөрөмж болон бусад хөрөнгийн төслийг хөтөлбөр болон төсвийн ерөнхийлөн захирагчаар тооцож тусгах;

8.4.2. шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар тооцож тусгах.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ
## Төсөл, арга хэмжээний санхүүжилт, гүйцэтгэлийн баримт бичиг

**Ес. Санхүүжилтийн ерөнхий зохицуулалт**

9.1 Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актад захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилж, томилсон тухай шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлнэ.

9.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь барилга захиалагчийн хяналт тавих этгээдтэй захиалагчийн хяналтын гэрээ заавал байгуулсан байх бөгөөд гэрээний хуулбарыг тухайн төслийн гүйцэтгэлийн материалд хавсаргаж Сангийн яаманд ирүүлнэ.

9.3 Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл эрх хүлээн авсан этгээд нь төсөл, арга хэмжээг батлагдсан төсөвт өртөгт багтаан худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын хүрээнд зохион байгуулах үүрэгтэй.

9.4 Санхүүжилтийн гүйцэтгэлийг тухайн төсөл, арга хэмжээний зураг төсөл болон төсвийн дагуу барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийг үндэслэн барилга угсралтын гэрээнд тусгасан үе шатны ажил тус бүрээр гаргаж, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй тулган шалгаж, хянан баталгаажуулна.

9.5 Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл төсвийн шууд захирагч нь санхүүжилтийн гүйцэтгэлийг энэ журмын Хавсралт №7, №8, №9-д заасан маягтуудын дагуу баталж, санхүүжилт хүссэн албан бичгийг Сангийн яаманд ирүүлнэ.

9.6 Захиалагч болон Сангийн яам нь энэ журмын хавсралтад заасан тухайн төсөлд тохирох хяналтын хуудсыг хөтөлж, санхүүгийн баримт болгон гүйцэтгэлийн материалд хавсаргана.

9.7 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж Захиалагчаас хянан баталгаажуулж ирүүлсэн гүйцэтгэлийн материал нь энэ журмын холбогдох хавсралтад заасан хяналтын хуудаст тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа тохиолдолд ажлын 3 хоногийн дотор тухайн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эрхийг нээнэ.

9.8 Энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжид нийцсэн, хяналтын хуудас бүрэн бөглөгдсөн тохиолдолд Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Хавсралт №14-т заасан маягтын дагуу Төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

9.9 Энэхүү журмын 9.8-д заасан жагсаалтад Төсвийн тухай хуулийн хавсралтад тэмдэглэгдсэн хөрөнгө оруулалтын ажлын нэр, дэс дугаар, захиалагч, гүйцэтгэгчийн нэр, захиалагчийн дансны дугаар, санхүүжих мөнгөн дүнг тус тус тэмдэглэсэн байна.

9.10 Хяналтын хуудас бүрэн бөглөгдөх боломжгүй, санхүүжилтийн материал иж бүрдэл дутуу, шаардлага хангахгүй, тэдгээрт тусгагдсан асуудал холбогдох хууль, тогтоомжид нийцээгүй бол Сангийн яам захиалагчаас ирүүлсэн

материалыг ажлын 3 хоногийн дотор цахимаар болон албан бичгээр буцаана.

9.11 Эрх шилжүүлсэн төсөл, арга хэмжээний хувьд эрх шилжүүлсэн тухай шийдвэр нь тухайн захиалагчийн холбогдох дансанд санхүүжилтийн эрхийг нээх үндэслэл болно.

9.12 Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг гүйцэтгэлээр олгох бөгөөд урьдчилгааг дараах тохиолдолд олгоно. Үүнд:

9.12.1 тухайн төсөл, арга хэмжээнд урьдчилгаа олгох талаар худалдан авах ажиллагааны баримт бичиг болон гэрээнд тусгасан байх;

9.12.2 урьдчилгаа төлбөрийн баталгаа гаргуулсан байх */Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Урьдчилгаа төлбөрийн баталгааны маягт"-ын дагуу гаргана/;*

9.12.3 банкны урьдчилгаа төлбөрийн баталгааг үндэслэн санхүүжилтийг олгоход урьдчилгаа төлбөрийн банкны баталгааг банканд байршуулсан эсэх баримтыг санхүүжилт хүсэх баримтад хавсаргасан байх;

9.12.4 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөрөнгө оруулалтын улсын төсвийн санхүүжилтээр санхүүжих төсөл, арга хэмжээний урьдчилгаа төлбөрийн нийт хэмжээ нь тухайн онд батлагдсан нийт санхүүжилтийн 30 хувиас ихгүй байна.

9.13 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд зөвхөн уг ажилд захиалагчаас гадна захиалагчийг төлөөлж техник хяналт, зохиогчийн хяналт тавьж байгаа болон санхүүжилтийн үйл ажиллагаанд оролцогч эрх бүхий этгээд гарын үсэг зурна.

9.14 Төсөл, арга хэмжээний гүйцэтгэгч этгээдийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу шалгаруулж, гэрээ байгуулах бөгөөд гэрээтэй холбоотой аливаа зохицуулалтыг гэрээний тусгай нөхцөлд тусгана.

9.15 Барилга байгууламж болон их засварын ажлын төсөвт өртөгт барилгын үнэ бүрдлийн дүрэмд тусгасны дагуу зохиогчийн хяналт, захиалагчийн хяналт, магадлашгүй ажил, нэмэгдсэн өртгийн албан татвар, зураг төсөл, хайгуулын ажил, барилга байгууламжийн норм, нормативын сангийн шимтгэл гэх мэт нэгбүрчилсэн төсвийн зардлыг тооцно.

9.16 Магадлашгүй ажлын зардлыг барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон актын дагуу зураг төсөлд тусгагдаагүй ажлыг санхүүжүүлэхэд зарцуулах бөгөөд уг зардлыг хурлын тэмдэглэл, магадлашгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэлийг үндэслэн олгоно.

9.17 Зураг төсөл боловсруулсан зардал, зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төсөл дээр байгуулсан гэрээ, хийсэн ажлын тайлангийн дагуу холбогдох норм дүрэмд заасныг үндэслэн энэ журмын Хавсралт №16-д заасан маягтыг бөглөж олгоно.

9.18 Төсвийн орлого бүрдүүлэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс хамаарч тогтоосон хугацаанд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь санхүүжилт авч чадаагүй бол энэ нь хариуцлага хүлээлгэх үндэслэл болохгүй.

9.19 Төсвийн орлого бүрдүүлэлт, эх үүсвэр хүрэлцээгүйгээс энэхүү журмын 9.7-д заасан хугацаанд төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх боломжгүй нөхцөл үүссэн тохиолдолд Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний

санхүүжилтийн эрхийг нээхдээ зөвхөн тэдгээрийн Сангийн яаманд бүртгэгдсэн огнооны дарааллыг баримтална.

9.20 Захиалагч байгууллага өөрийн дансанд санхүүжилт орсноос хойш ажлын 2 хоногийн дотор гүйцэтгэгч байгууллагад санхүүжилтийг олгоно. Санхүүжилтийг тогтоосон хугацаанд гүйцэтгэгчид шилжүүлээгүйгээс үүдэн гарах бүх хариуцлагыг захиалагч хариуцна.

9.21 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зохицуулалт хийх шалтгаан нөхцөл үүссэн тохиолдолд санхүүжилтийн дүнд өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилтийг захиалагч болон Сангийн яам төлөвлөгөө батлагдтал түр хугацаагаар зогсоож, шинэчлэгдсэн төлөвлөгөө батлагдсаны дараа шийдвэрлэнэ.

9.22 Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс Засгийн газрын худалдан авах ажиллагааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон орон нутагт эрх шилжин худалдан авах ажиллагааг нь зохион байгуулах ажлын жагсаалтыг тушаалаар баталж, худалдан авах ажиллагааныхаа төлөвлөгөөнд хавсарган төсөв батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Сангийн яаманд хүргүүлсэн байна.

9.23 Төсвийн ерөнхийлөн захирагч болон Аймаг, нийслэлийн Засаг даргын төрийн сан дахь хөрөнгө оруулалтын данс төсвийн жилийн эцэст үлдэгдэлгүй байх бөгөөд энэ нь барьцаа хөрөнгийн болон техник хяналтын дансанд хамаарахгүй.

9.24 Захиалагч нь барилга байгууламж, их засварын ажил, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээ зэрэг хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ тус бүрийн хяналтын хуудсыг энэхүү журмын Хавсралтад заасан маягтын дагуу бөглөн баталгаажуулж ирүүлнэ.

9.25 Төсөл, арга хэмжээний эцсийн санхүүжилт ирүүлэхэд гэрээг дүгнэсэн байх ёстой бөгөөд Хавсралт №12-т заасан "Гэрээ дүгнэх маягт"-ыг үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

9.26 Эцсийн санхүүжилтийг авахад тухайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглагч байгууллага нь бүртгэлд тусгасныг нотлох баримт үйлдэж баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

9.27 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсвөөс санхүүжүүлэхийг хориглоно.

9.28 Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

9.29 Төсвийн орлого бүрдүүлэлтээс хамаарч тогтоосон хугацаанд төсөл, арга хэмжээ нь санхүүжилт авч чадаагүй бол тухайн хугацаагаар төсөл, арга хэмжээний гэрээний хугацааг санхүүжилт орсон өдөр хүртэл хойшлуулан тооцож санхүүжилт гаргана.

9.30 Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь урьдчилсан худалдан авах ажиллагаанд хамаарч буй тохиолдолд гүйцэтгэлийн материалд уг төсөл, арга хэмжээг баталсан Засгийн газрын тогтоолыг хавсаргаж ирүүлнэ.

9.31 Урьдчилгаа төлбөрийн банкны баталгаа болон барилгын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд Сангийн яам

нь санхүүжилтийг зогсоож, энэ талаар арга хэмжээ авахуулахаар асуудлыг Захиалагч болон холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлнэ.

**Арав. Барилга байгууламжийн ажлын санхүүжилт**

10.1 Барилга байгууламжийн ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт нь Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад нийцсэн байна.

10.2 Барилга байгууламжийн ажил нь барилга байгууламжийг төлөвлөх, барилгын ажил гүйцэтгэхэд шаардагдах техник, эдийн засгийн үндэслэл, техникийн болон ажлын зураг, барилгын ажил гүйцэтгэх талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын төсөл, инженер хайгуулын судалгаа, инженер геологи, геодезийн зураглал, инженерийн тооцоо, өртгийн төсөв зэрэг баримт бичгийн иж бүрдлийг хангасан байна.

10.3 Захиалагчийн барилга байгууламжийн ажлын санхүүжилт хүссэн материалыг Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх олгосны дагуу Төсвийн шууд захирагч эсхүл санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн даргын гарын үсгээр хянан баталгаажуулах бөгөөд албан бичиг болон Цахим системээр дамжуулан Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

10.4 Захиалагч барилга байгууламжийн ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон барилга угсралтын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлж, энэ журмын холбогдох Хавсралтад заасан маягтын дагуу гаргана.

10.5 Сангийн яаманд ирүүлэх гүйцэтгэлийн материалд Хавсралт №7-д заасан "Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга угсралтын ажлын санхүүжилтийн хүсэлтийн маягт"-ийн дагуу санхүүжилтийн хүсэлтийг баталгаажуулж ирүүлнэ.

10.6 Захиалагч нь төсөл, арга хэмжээний эцсийн санхүүжилтийн хүсэлтийг ирүүлэхдээ барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад оруулах улсын комиссын актаар ашиглалтад хүлээн авсан байна.

10.7 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж хянан баталгаажуулж, холбогдох материалыг энэхүү журмын Хавсралт №2 болон №3 дахь хяналтын хуудаст тусгагдсан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж байгаа эсэхийг дараах материалыг үндэслэн санхүүжүүлнэ. Үүнд:

- 10.7.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай албан бичиг, үнэлгээний хорооны шийдвэр;
- 10.7.2 захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь /Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Гэрээний маягт"-ын дагуу гэрээг байгуулна/;
- 10.7.3 тухайн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнг цахим систем /tender.gov.mn/-д оруулсныг нотлох баримт;
- 10.7.4 захиалагч болон гүйцэтгэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээний эх хувь /Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Гэрээний маягт"-ын дагуу гэрээг байгуулна/;
- 10.7.5 эрх шилжүүлсэн тохиолдолд холбогдох шийдвэрийн хуулбар;
- 10.7.6 тендер шалгаруулалтад шалгарч гэрээ байгуулсан этгээдийн барилга угсралт, их засварын ажлын төлөвлөгөө, түүнийг төсөвт өртөгт эзлэх

дүнгээр тодорхойлсон барилгын ажлын үе шатны хуваарь /энэ журмын Хавсралт №9-д заасан маягтын дагуу гаргана/;

10.7.7 гүйцэтгэлийн баталгаа /Сангийн сайдын тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн баталгааны маягт"-ын дагуу гаргана/;

10.7.8 захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл /энэ журмын Хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана/;

10.7.9 барилга, байгууламжийн ажлын гүйцэтгэлийг нотлох гэрэл зураг /10-аас ихгүй байх/;

10.7.10 магадлашгүй ажлын зардлын барилгын гүйцэтгэгч, захиалагч байгууллагууд харилцан тохиролцсон акт, хурлын тэмдэглэл, магадлашгүй ажлын төсөв, баримтжуулсан фото зураг болон гүйцэтгэл;

10.7.11 зураг төсөл боловсруулах гэрээ, зохиогчийн хяналт, захиалагчийн хяналтын тухайн төсөл дээр байгуулсан гэрээний хуулбар, хийсэн ажлын тайлан;

10.7.12 барилга байгууламжийн ажлыг байнгын ашиглалтад хүлээн авсан тухай улсын комиссын актыг үйлдэж, комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана;

10.7.13 захиалагчийн хянаж баталгаажуулсан барилгын ажлын ил далд ажлын акт;

10.7.14 төрийн худалдан авах ажиллагааны цахим хуудаст тендер шалгаруулалтын мэдээллийг бүрэн оруулсан байх.

10.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар худалдаж авах төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Хавсралт №3-т заасан хяналтын хуудсыг хөтөлж олгоно.

10.9 Барилга байгууламжийн чанарын баталгаат хугацааг Барилгын тухай хуулийн 14.6-д, авто замын байгууламжийн тухайд Авто замын тухай хуулийн 28.4-т заасныг тус тус баримтлах бөгөөд баталгаат хугацаанд байгалийн болон давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад шалтгаанаас үүдэн барилга байгууламжид аливаа доголдол, эвдрэл, гэмтэл гарвал Захиалагч нь гүйцэтгэгч байгууллагаар үнэ төлбөргүй, үл маргах журмаар засварлаж, ашиглалтын хэвийн байдалд оруулах арга хэмжээ авна.

## Арваннэг. Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилт

11.1 Захиалагч их засварын ажлын гүйцэтгэлийг ирүүлэхдээ гэрээгээр тохиролцсон их засварын ажлын календарьчилсан төлөвлөгөө болон ажлын бодит гүйцэтгэлийг мөнгөн дүнгээр илэрхийлсэн байдлаар гаргаж, энэ журмын Хавсралт №8 болон №9-д заасан маягтын дагуу гаргана.

11.2 Захиалагч нь их засварын ажлыг комиссын актаар ашиглалтад хүлээн авна.

11.3 Их засварын ажлыг хийж дууссаад комисс ажиллан хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэлийг баримт бичгийн иж бүрдэлд хангана.

11.4 Захиалагч худалдан авсан тоног төхөөрөмжийг комисс байгуулан тухайн тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, чанарын баталгаа, иж бүрдэл зэргийг бүрэн хэмжээгээр шалгаж хүлээж авах бөгөөд хүлээн авах комисс томилсон шийдвэр, комиссын гишүүдийн саналын хуудас, хурлын тэмдэглэл, Хавсралт №11-т заасан магтын дагуу тоног төхөөрөмж хүлээн

авсан акт зэргийг үйлдэж санхүүжилтийн баримт бичгийн иж бүрдэлд хавсаргана.

11.5 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь тоног төхөөрөмжийн санхүүжилтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн Хавсралт №6-д заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.

11.6 Их засвар, тоног төхөөрөмжийн санхүүжилтэд энэ журмын 9 болон 10 дугаар зүйлд заасан холбогдох зохицуулалт мөн адил үйлчилнэ.

**Арванхоёр. Зөвлөх үйлчилгээний ажлын санхүүжилт**

12.1 Зөвлөх үйлчилгээний ажлыг холбогдох хуульд зааснаар тодорхойлох бөгөөд зөвлөх үйлчилгээний хүрээнд хийгдэх ТЭЗУС болон ТЭЗҮ-д дараах ажлууд хамаарна. Үүнд:

12.1.1 ТЭЗУС-ны хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага, зорилт, хүрэх үр дүн, нийгэм, эдийн засгийн үр нөлөө, зардал, үр ашиг, хэрэгжүүлэх арга замыг урьдчилсан байдлаар тоймлон судлах, хэрэгжих боломжийг тоймлон тогтоох судалгааны ажил болон холбогдох тайланг боловсруулах;

12.1.2 ТЭЗҮ боловсруулах ажилд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг эрэлт хэрэгцээ, нөөц боломж, техник-технологи, эдийн засаг, хууль эрх зүй, үйл ажиллагаа болон цаг хугацааны хувьд хэрэгжих боломжийг судлан тогтоох, тухайн төслийн үр дүн болон үр ашгийг тодорхойлох, гарч болзошгүй эрсдэл, зардлуудыг тодорхойлох судалгааны ажил болон холбогдох тайланг бэлтгэх.

12.2 Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл түүний эрх шилжүүлснээр хэрэгжүүлж буй төслийн ажилд шаардлагатай зөвлөх үйлчилгээний зорилт, хүрэх үр дүн болон бусад шаардлагатай мэдээллийг агуулсан ажлын даалгавар бэлтгэж, зөвлөхийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар сонгон шалгаруулах ба зөвлөх үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг сонгож, гэрээ байгуулна.

12.3 Зөвлөх үйлчилгээний ажлын даалгавар нь түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хамт тухайн зөвлөхтэй байгуулах гэрээний салшгүй хэсэг болно.

12.4 Зөвлөх үйлчилгээний төсөвт өртгийг тооцохдоо боловсон хүчний мэргэжлийн чиглэл, түвшин, зөвлөхийн ажлын талбайд болон төв байранд ажиллах хугацаа, бичиг хэргийн болон тухайн үйлчилгээнд шаардлагатай бусад зардалд үндэслэсэн байна.

12.5 Захиалагч ажлын даалгавар бэлтгэж, төсөвт өртгийг тооцоолж гаргасны дагуу ажил гүйцэтгэх гэрээнд тусгаж ажиллана.

12.6 Зөвлөх үйлчилгээний зардлыг олгох санхүүжилтийн материалд гэрээний эх хувь, зохиогчийн хяналтын зардал өгөх тохиолдолд зохиогчийн хяналтын гэрээ, магадлалаар баталгаажсан зураг төсөл болон төсөв тус бүрийн эх хувь, эсхүл хуулбар, хүлээн авсан акт заавал хавсаргана.

12.7 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь Зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн Хавсралт №5-д заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.

**Арвангурав. Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилт**

13.1 Концессын гэрээний эргэн төлөлтийг төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр олгох асуудлыг концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилттэй холбогдон гарсан хууль, эрх зүйн акт, Улсын Их Хурал, Засгийн газар болон холбогдох байгууллагын шийдвэрт үндэслэн санхүүжүүлнэ.

13.2 Концессын гэрээний дагуу гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний төлбөрийг гэрээний үнийн дүнгээс хэтрүүлэхгүйгээр санхүүжүүлэх бөгөөд бодит гүйцэтгэл нь гэрээний үнийн дүнгээс бага бол эргэн төлөлтийг бодит гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

13.3 Төсвийн ерөнхийлөн захирагч болон концессын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь концессын эргэн төлөлттэй холбогдолтой санхүүгийн болон бусад холбогдох баримт бичгийн үнэн зөв эсэхийг хянан баталгаажуулж, тухайн санхүүжилтийн дүнг тусгасан албан бичгээр болон Цахим системд Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

13.4 Концессын гэрээний эргэн төлөлтийн санхүүжилтийг шийдвэрлэхэд дор дурдсан баримт бичгийн иж бүрдлийг хангасан байна. Үүнд:

13.4.1 Концессын тухай хууль болон Засгийн газрын 2012 оны 103 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Концесс олгох уралдаант шалгаруулалтын журам”-аар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон тухай холбогдох байгууллагын шийдвэр дүгнэлт, хурлын тэмдэглэл;

13.4.2 захиалагчийн зүгээс концессын гэрээнд заасан уг гэрээг хүчин төгөлдөрт тооцох нөхцөлүүд хангагдсан эсэх талаарх дүгнэлт;

13.4.3 концессын гэрээ дуусгавар болсонтой холбогдуулан гэрээний талууд гэрээг эцэслэн дүгнэсэн дүгнэлт;

13.4.4 концессын гэрээнд өөрчлөлт оруулсан бол гэрээний нэмэлт өөрчлөлт болон эргэн төлөлтийн хуваарийг дараа онуудад шилжих дүнг төгрөгөөр илэрхийлсэн байх;

13.4.5 санхүүжилттэй холбогдон гарсан тогтоол, шийдвэрийн дагуу хөндлөнгийн байгууллагын дүгнэлт, зөвлөмж болон тухайн төсөл, арга хэмжээтэй холбогдон гарсан дүгнэлт, зөвлөмжийн дагуу шаардлагатай материал;

13.4.6 Концессын гэрээ байгуулах эрх олгох тухай Засгийн газрын тогтоолын хуулбар;

13.4.7 захиалагч болон концесс эзэмшигчийн хооронд байгуулсан концессын гэрээний эх хувь, эсвэл захиалагч байгууллага хянаж, нотариатаар баталгаажуулсан концессын гэрээний хуулбар хувь байж болно;

13.4.8 захиалагчийг төлөөлсөн эрх бүхий албан тушаалтнуудын гарын үсэг, тамга, тэмдгээр хянан, баталгаажсан барилгын ажлын гүйцэтгэл, гэрээнд багтсан санхүүгийн бусад зардал нэг бүрээр концесс эзэмшигчтэй тооцоо нийлсэн акт;

13.4.9 барилга, байгууламж, засварын ажил, тоног төхөөрөмжийн гэрэл зураг;

13.4.10 ТЭЗҮ, зураг төсөл болон төсөв, техник хяналт, зөвлөх үйлчилгээний гэрээний хуулбар, захиалагчийн хяналтын гэрээ дүгнэсэн дүгнэлт;

13.4.11 барилга байгууламж, их засварын ажлыг ашиглалтад хүлээн авсан тухай комиссын акт, тоног төхөөрөмж хүлээн авсан акт;
13.4.12 төсвийн шууд захирагчийн хянан баталгаажуулсан санхүүжилтийн дүнтэй албан бичиг;
13.4.13 магадлашгүй ажлын акт, төсөв, гүйцэтгэл, баримтжуулсан фото зураг, хурлын тэмдэглэл.

13.5 Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь концессын гэрээний эргэн төлөлтийг олгохдоо энэ журамд заасан шаардлагыг хангасан эсэхийг үндэслэн Хавсралт №4-т заасан хяналтын хуудсыг хөтөлж, санхүүжилтийн эрхийг нээнэ.

13.6 Концессын асуудал хариуцсан байгууллага нь концессын гэрээгээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг холбогдох нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу бүртгэж, санхүүгийн тайланд тусгана.

13.7 Энэ журмын 13.4-т заасан баримт бичгийн бүрдлийн үнэн зөв эсэхийг захиалагч буюу төсвийн захирагч бүрэн хариуцна.

## ТАВДУГААР БҮЛЭГ
## Ил тод байдал, хяналт, тайлагналт, үр дүн

**Арвандөрөв. Санхүүжилтийн ил тод байдал**

14.1. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг олгохтой холбоотой баримт материалуудыг энэхүү журамд дурдсанаар бүрдүүлж, албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэхээс гадна цахим системийн "Санхүүжилтийн гүйцэтгэл" гэсэн цэсэд оруулж, давхар баталгаажуулж олон нийтэд мэдээлнэ.

14.2. Цахим системд нэвтрэх баталгаажуулах хэрэглэгчийн эрхийг санхүүжилтийн үйл ажиллагаанд оролцогч болох гүйцэтгэгч, захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллага, захиалагч, Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалт болон төрийн сангийн асуудал хариуцсан нэгж зэрэг байгууллагуудад олгоно.

14.3. Гүйцэтгэгч байгууллагын цахим системд нэвтрэх эрхийг захиалагч байгууллага, бусад хэрэглэгчийн эрхийг Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж олгоно.

14.4. Тухайн ажлыг гүйцэтгэсэн гүйцэтгэгч нь гэрээт ажлын санхүүжилтийг авах хүсэлтээ тухай бүр албан бичгээр болон цахим системд холбогдох мэдээллийг оруулж, цахим системээс хэвлэгдэх Хавсралт №15-д заасан маягтыг гүйцэтгэлийн материалд хавсарган дараагийн шатны байгууллагад илгээж, хүргүүлнэ.

14.5. Захиалагчийн хяналт тавьж байгаа байгууллага нь гүйцэтгэгчийн материалыг хүлээн авч, ажлын 5 хоногийн дотор хянан баталгаажуулж, гэрээ байгуулсан этгээд буюу захиалагчид албан бичгээр хүргүүлэх бөгөөд цахим системд энэ талаар баталгаажуулна.

14.6. Захиалагч нь гүйцэтгэлийг ажлын 2 хоногийн дотор хянан баталгаажуулж, санхүүжилтийн хүсэлтийг албан бичгээр болон Цахим системд Сангийн яаманд хүргүүлнэ.

14.7. Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгж нь санхүүжилтийн хүсэлтийг хүлээн авч, тухайн ажлын санхүүжилт олгох үндэслэл, нөхцөлийг хянах бөгөөд санхүүжилтийн эрхийг нээсэн тохиолдолд Цахим системд баталгаажуулан тус яамны Төрийн сангийн асуудал хариуцсан нэгжид хүргүүлнэ.

14.8. Сангийн яамны төрийн сангийн асуудал хариуцсан нэгж захиалагчийн төрийн санд шилжих процессыг Цахим системд баталгаажуулах ба Захиалагчийн төрийн сангийн нэгж нь гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохдоо цахим системд баталгаажуулна.
14.9. Санхүүжилтийн гүйцэтгэлийн мэдээллийг цахим системд оруулж, баталгаажуулаагүй тохиолдолд санхүүжилтийг олгох боломжгүй болно.
14.10. Нууцын тухай хууль тогтоомж, талуудын гэрээнд зааснаас бусад тохиолдолд төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үйл ажиллагаа, мэдээлэл болон бүртгэл, тайлагналт нь ил тод байна.
14.11. Цахим системийн мэдээллийг олон нийтэд зориулсан www.publicinvestment.gov.mn цахим хуудаст байршуулах бөгөөд андройд болон iOS үйлдлийн системд ажиллах боломжтой "төсвийн хөрөнгө оруулалт" болон "publicinvestment" нэр бүхий аппликейшнаар дамжуулан мэдээллийг нийтэд хүргэнэ.
14.12. Санхүүжилтийн хүсэлтийг албан бичгээр ирүүлэхээс гадна цахим системд баталгаажуулах шаардлагатай бөгөөд холбогдох байгууллагууд цахим системд дээд тал нь 10 удаа илгээгээгүй тохиолдолд энэ нь тухайн албан тушаалтанд хариуцлага тооцох үндэслэл болно.
14.13. Санхүүжилтийн үйл ажиллагааг цахимд системд оруулахдаа гарын авлагыг мөрдлөг болгож ашиглана.

**Арвантав. Хяналт**

15.1 Захиалагчийн хяналтыг гэрээгээр гүйцэтгэж буй Захиалагч, захиалагчийг төлөөлж буй байгууллага нь төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа барилга байгууламж, их засварын ажилд захиалагчийн хяналтыг тавьж, хэмжилт шалгалтыг Барилгын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, норм, стандартад заасны дагуу хэрэгжүүлнэ.
15.2 Захиалагч, захиалагчийг төлөөлж хяналт тавьж байгаа байгууллага барилга байгууламж, их засварын ажлын гүйцэтгэл, чанарт байнгын шууд хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1.4-д заасан нөхцөл байдал илэрсэн бол холбогдох мэдээллийг эрх бүхий улсын байцаагчид хүргүүлэх зэрэг арга хэмжээг тухай бүр авч ажиллана.
15.3 Захиалагч нь барилга байгууламжийн ажлын үе шат бүрт зохиогчоор хяналт тавиулж, дүгнэлт гаргуулна.
15.4 Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилтийн зарцуулалтын байдалд хяналт тавьж, шаардлагатай бол барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж худалдан авах, зөвлөх үйлчилгээний ажилд шалгалт хийж, зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авна. Үүнд хяналт, шалгалтын мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж болно.
15.5 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.
15.6 Захиалагч байгууллага төсвийн хөрөнгөөр хийгдэж буй барилга байгууламж, их засварын ажил бүрийг биечлэн хянаж, шалгах үүрэг бүхий хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх компанийг ажиллуулах бөгөөд хяналтын инженер, хяналтын зөвлөх үйлчилгээ үзүүлж

буй компани нь хяналт хийсэн тухай бүр тэмдэглэл үйлдэж, гүйцэтгэгч байгууллагад өгөгдсөн үүрэг даалгавар, түүний биелэлтийн талаар тэмдэглэж ажлын гүйцэтгэлд хавсаргаж, их засварын ажил дууссаны дараа санхүүжилтийн материалын хамт захиалагчийн архивд хадгалуулна.

15.7 Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй төсөл, арга хэмжээний санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудалд төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн нутгийн захиргааны байгууллага, орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудаар хөндлөнгийн хяналт тавиулж болно.

15.8 Орон нутагт хийгдэж байгаа төсвийн хөрөнгө оруулалтын ажилтай холбоотой асуудлаар иргэд гомдол гаргавал нутгийн захиргааны байгууллага өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх, боломжгүй бол асуудлыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч, хяналт шалгалтын мэргэжлийн байгууллага, Сангийн яаманд цаг алдалгүй тавьж шийдвэрлүүлнэ.

**Арванзургаа. Тайлагналт, үр дүн**

16.1 Сангийн яам төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажил тус бүрийн санхүүжилтийн дүн, явц байдлыг энэ журмын Хавсралт №8-д заасан маягтын дагуу тогтмол гаргаж, төсвийн ил тод мэдээллийн сайтад байршуулна.

16.2 Төсвийн ерөнхийлөн захирагч болон аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Цахим системд тухай бүр журамд зааснаар тусгах бөгөөд тухайн байгууллагын мэдээллийн сүлжээнд шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байна.

16.3 Захиалагч байгууллага нь барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр бусад эргэлтийн хөрөнгөөр тус тус бүртгэн санхүүгийн тайландаа тусгана.

16.4 Захиалагч байгууллага нь их засварын ажлын зардлыг засварын ажлыг хүлээлгэн өгсөн актыг үндэслэн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

16.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн бүртгэл, өмчлөлийн асуудлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

16.6 Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн тайланг сар бүр энэ журмын Хавсралт №10-т заасан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

16.7 Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад батлагдсан боловч худалдан авах ажиллагаа нь орон нутагт эрх шилжин хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар нь сар бүр энэ журмын Хавсралт №10-т заасан маягтын дагуу гаргаж, дараа сарын 5-ны дотор Сангийн яам болон холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

16.8 Төсвийн ерөнхийлөн захирагч нь ашиглалтад орсон барилга байгууламжийн мэдээг дараа оны 4 дүгээр сарын 10-ны дотор энэ журмын Хавсралт №13-т заасан маягтын дагуу гаргаж Сангийн яаманд хүргүүлнэ.

16.9 Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний ажлын төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилтийн холбогдолтой бүх баримт, материал, комиссын актуудыг хариуцсан албан тушаалтан Архивын тухай хуулийн дагуу архивлаж хадгална.

16.10 Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээ тус бүрийн талаар дараах мэдээллийг агуулсан тайланг тогтмол гаргах бөгөөд санхүүгийн дүн тооцоог өөрийн байгууллагын санхүүгийн жилийн тайланд тусгаж тайлагнана:

16.10.1 төслийн танилцуулга;

16.10.2 гэрээнд заасан урт хугацаанд бэлэн мөнгөний урсгал, санхүүгийн нөлөө үзүүлж болох гэрээний гол нөхцөлүүд;

16.10.3 гэрээний зүйлийг ашиглах эрх, үйлчилгээг үзүүлэх үүрэг, хөдлөх, болон үл хөдлөх хөрөнгө, үйлдвэр, тоног төхөөрөмжийг өөрийн хөрөнгөнд шилжүүлэх, аливаа хөрөнгийг хүлээн авах, шилжүүлэх, гэрээг сунгах, цуцлах заалт, бусад үндсэн ашиглалт болон засвар үйлчилгээний талаарх мэдээлэл.

16.11 Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөл, арга хэмжээний төслийн үр дүнг дүгнэж, тухайн барилга байгууламж ашиглалтад орсноос хойш 2–3 жилийн дараа төслийн хүчин чадлын ашиглалтыг шалгаж, энэ талаарх мэдээллийг Сангийн яаманд хүргүүлнэ.

## ЗУРГААДУГААР БҮЛЭГ
## Бусад зүйл

### Арвандолоо. Бусад зүйл

17.1. Энэхүү журмыг хэрэгжүүлэх албан тушаалтан, мэргэжилтэн нь чиг үүргээ төсвийн сахилга бат, мэргэжлийн ёс зүйг баримтлан, хууль ёсны дагуу, ашиг сонирхлын зөрчилгүй, хараат бус, бие даан гүйцэтгэх ба тухайн этгээдийн хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүй нь холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.

17.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэн зөв гаргах, төсвийн хөрөнгийн зарцуулалт, барилгын чанарт тавих хяналтыг Төсвийн ерөнхийлөн захирагч бүрэн хариуцна.

17.3. Давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй нөхцөл байдлын улмаас Цахим систем ажиллах боломжгүй болсон тохиолдолд материал хүлээн авах хугацааг хойшлуулж Төсвийн ерөнхийлөн захирагчид энэ тухай мэдэгдэнэ.

17.4. Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн жагсаалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мэдээллийг www.iltod.gov.mn, https://mof.gov.mn цахим хуудаст тухай бүр мэдээлнэ.

17.5. Энэхүү журмын 16.9-д зааснаар баримт материалыг архивт өгөөгүй тохиолдолд холбогдох хариуцлагыг тухайн асуудал хариуцсан албан тушаалтны удирдлага хүлээнэ.

17.6. Энэ журамд заасныг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

17.7. Гэрээний талууд нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй бол гэрээ болон холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага ногдуулна.

Хавсралт №1

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТИЙН МАЯГТ

| Дугаар | Аймаг, Нийслэл | Сум, Дүүрэг | ТЕЗ-ийн оноо | Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил | Хэмжих нэгж | Хүчин чадал | Объектын төрөл | Объектын ангилал | Хугацаа | | Төслийн төсөвт өртөг онуудад /сая төг/ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | Эхлэх | Дуусах | Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн төсөвт өртөг | | | | | | |
| 1. | | | | | | | | | | | | | | | | | |

| Санхүүжилт /сая төг/ | | | | | | | | Нийт авсан санхүүжилт /сая төг/ | Байгууллагын санал | | Он дамжин хэрэгжих бил дараагийн жилийн санхүүжилт | Төсвийн ерөнхийлөн захирагч |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тухайн төсөл хэрэгжиж эхэлсэн оноос төлөвлөж буй он хүртэлх жил бүрийн санхүүжсэн дүн | | | | | | | | | Төсвийн төсөлд тусгах төсөвт өртөг /сая төг/ | Төсвийн төсөлд тусгах санхүүжих дүн /сая төг/ | | |
| | | | | | | | | | | | | |

| Аргачлалын дагуу холбогдох мэдээлэл байгаа эсэх | | | | | Ажлын явц хувь \шилжих төслийн хувьд\ | Гүйцэтгэгч компани \Шилжих төслийн хувьд\ | Худалдан авах ажиллагааны мэдээлэл Шилжих төслийн хувьд\ | | | Дэлгэрэнгүй тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Төслийн шинжилгээ хийгдсэн эсэх | Батлагдсан зураг төсөл болон төсөв | Газрын зөвшөөрөл | Техникийн нөхцөл | Оноо өгөгдсөн эсэх | | | Тендер зарласан огноо | Гэрээ байгуулсан огноо | Тендер зарлаагүй гэрээ байгуулаагүй | |
| | | | | | | | | | | |

**-Жил бүр Төсвийн төсөл боловсруулах удирдамжийн хамт Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх маягт, үүний дагуу албан бичгээр болон дээрх хүснэгтийн мэдээллийг цахим системд оруулна.*

Хавсралт №2

# БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүч чадал, байршил....................................
Гэрээний дугаар.............................................................................
Гүйцэтгэлийн дугаар..........                                    Гүйцэтгэгчийн нэр ................
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

| Д/Д | Шалгуур үзүүлэлт, шаардлага | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томьёотой тохирч байгаа эсэх | | |
| 2 | Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх<br>*/Нийт төсөвт өртөг нь ТБОНӨХБАҮХА хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/* | | |
| 3 | Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх | | |
| 4 | Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх, тендер шалгаруулалтын үр дүнг tender.gov.mn-д оруулсан эсэх | | |
| 5 | Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт */яамдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЗД-ын гарын үсэгтэй байх/* ирүүлсэн байх | | |
| 6 | Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнийн дүн эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтрээгүй эсэх | | |
| 7 | Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх | | |
| 8 | Гүйцэтгэлээр санхүүжилт авах тохиолдолд энэ журмын 10, 11 дүгээр зүйлд тусгагдсан материалыг бүрэн ирүүлсэн байна | | |
| 9 | Урьдчилгаа авах тохиолдолд энэ журмын 9.12.1-9.12.4-т заасан болон журамд заасан бусад материалыг бүрэн ирүүлсэн байна | | |
| 10 | Ажлын гүйцэтгэл болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх | | |
| 11 | Ажлын гүйцэтгэл болон урьдчилгаа төлбөр, гүйцэтгэлийн баталгаанууд батлагдсан маягтын дагуу гаргагдсан эсэх | | |
| 12 | Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх | | |
| 13 | Барилга угсралт, их засварын ажлын төсөвт өртөг Төсвийн тухай хуулийн 29.7-д зааснаас бусад тохиолдлоор өсөн нэмэгдээгүй байх | | |
| 14 | Барилга угсралтын ажлын гүйцэтгэл дэх шууд зардлын дүн нь гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг мөнгөн дүнгээр илэрхийлсэн хувь хэмжээтэй тохирсон, эсхүл ихгүй байх | | |
| 15 | Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх | | |
| 16 | Барилга угсралтын болон их засварын ажил нь хувийн, эсхүл өмчийн бусад хэлбэрийн этгээдийн өмчлөлийн зүйлд хийгдээгүй байх | | |
| 17 | Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх | | |

*Тайлбар:*
*"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.*

**ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:......................................................................./Нэр, Гарын үсэг/**

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:......................................../Нэр, Гарын үсэг/**

**огноо**

Хавсралт №3

# ХУДАЛДАН АВАХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН САНХҮҮЖИЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүч чадал, байршил....................................
Гэрээний дугаар............................................................
Гүйцэтгэлийн дугаар........... Гүйцэтгэгчийн нэр ................
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

| Д/Д | Шалгуур үзүүлэлт, шаардлага | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томьёотой тохирч байгаа эсэх | | |
| 2 | Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх *Нийт төсөвт өртөг нь ТБОНӨХБАҮХА хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/* | | |
| 3 | Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх | | |
| 4 | Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх, тендер шалгаруулалтын үр дүнг tender.gov.mn-д оруулсан эсэх | | |
| 5 | Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт */яамдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЗД-ын гарын үсэгтэй байх/* ирүүлсэн байх | | |
| 6 | Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнэ эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтрээгүй эсэх | | |
| 7 | Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх | | |
| 8 | Санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх | | |
| 9 | Худалдан авах үнийг үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөл бүхий этгээдээр үнэлгээ хийлгэсэн байх | | |
| 10 | Барилгын чанар, стандарт нь ашиглалтын шаардлага хангаж байгаа талаар захиалагч болон ашиглагч байгууллагын дүгнэлттэй байх | | |
| 11 | Үл хөдлөх хөрөнгийн болон газар эзэмших эрхийн гэрчилгээг захиалагч эсхүл ашиглагч байгууллагын өмчлөлд шилжүүлсэн байх | | |
| 12 | Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх | | |
| 13 | Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх | | |
| 14 | Барилга угсралтын болон их засварын ажил нь хувийн, эсхүл өмчийн бусад хэлбэрийн этгээдийн өмчлөлийн зүйлд хийгдээгүй байх | | |
| 15 | Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх | | |

*Тайлбар:*
*"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.*

**ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:............................................................................/Нэр, Гарын үсэг/**
**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:........................................../Нэр, Гарын үсэг/**

**огноо**

Хавсралт №4

## КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүч чадал, байршил....................................
Гэрээний дугаар...............................................................................
Гүйцэтгэлийн дугаар.................. Гүйцэтгэгчийн нэр .................
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

| Д/Д | Шалгуур үзүүлэлт, шаардлага | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан эсэх | | |
| 2 | Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томьёотой тохирч байгаа эсэх | | |
| 3 | Концесс олгох уралдаант шалгаруулалтын журмаар хуулийн дагуу сонгон шалгаруулсан шалгаруулсан эсэх *Концессын тухай хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/* | | |
| 4 | Гэрээ байгуулах эрх олгосон Засгийн газрын тогтоолын хуулбар | | |
| 5 | Концессын гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөл бүрдсэн эсэх | | |
| 6 | Энэ журмын 13.4-т тусгагдсан материалыг бүрэн ирүүлсэн эсэх | | |
| 7 | Ажлын гүйцэтгэл болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх болон санхүүжих дүнг тусгасан эсэх | | |
| 8 | Хөндлөнгийн аудитын дүгнэлттэй эсэх | | |
| 9 | Гэрээ дүгнэсэн протокол, дүгнэлттэй эсэх | | |
| 10 | Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх | | |
| 11 | Концессын гэрээгээр хэрэгжүүлсэн барилга, байгууламжийг ашиглагч байгууллагын бүртгэлд тусгах тухай баримт бичигтэй эсэх | | |
| 12 | Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн улсын комиссын акттай эсэх | | |

*Тайлбар:*
*"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.*

**ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:........................................................................./Нэр, Гарын үсэг/**

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:........................................./Нэр, Гарын үсэг/**

**ОГНОО**

Хавсралт №5

# ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүч чадал, байршил....................................
Гэрээний дугаар..........................................................................
Гүйцэтгэлийн дугаар.................. Гүйцэтгэгчийн нэр ................
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

| Д/Д | Шалгуур үзүүлэлт, шаардлага | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томьёотой тохирч байгаа эсэх | | |
| 2 | Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх<br>*/Нийт төсөвт өртөг нь ТБОНӨХБАҮХА хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/* | | |
| 3 | Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх | | |
| 4 | Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх, тендер шалгаруулалтын үр дүнг tender.gov.mn-д оруулсан эсэх | | |
| 5 | Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт */яамдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЗД-ын гарын үсэгтэй байх/* ирүүлсэн байх | | |
| 6 | Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнэ эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтрээгүй эсэх | | |
| 7 | Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх | | |
| 8 | Санхүүжилт авах тохиолдолд энэ журмын 12 дугаар зүйлд тусгагдсан материалыг бүрэн ирүүлсэн байна | | |
| 9 | Ажлын гүйцэтгэл болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх | | |
| 10 | Санхүүжүүлэх дүн нь сар, улирлын батлагдсан хуваарийн дахь өссөн дүнгээс хэтрэхгүй эсэх | | |
| 11 | Ажлын гүйцэтгэл болон урьдчилгаа төлбөр, гүйцэтгэлийн баталгаанууд батлагдсан маягтын дагуу гаргагдсан эсэх | | |
| 12 | Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх | | |
| 13 | Зөвлөх үйлчилгээний нийт өртөг Төсвийн тухай хуулийн 29.7-д заасанаас бусад тохиолдлоор өсөн нэмэгдээгүй байх | | |
| 14 | Зөвлөх үйлчилгээний шууд зардлын дүн нь гэрээгээр тохирсон барилгын ажлын төлөвлөгөөг мөнгөн дүнгээр илэрхийлсэн хувь хэмжээтэй тохирсон, эсхүл ихгүй байх | | |
| 15 | Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх | | |
| 16 | Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх | | |

*Тайлбар:*
*"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.*

**ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:........................................................................../Нэр, Гарын үсэг/**

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:......................................../Нэр, Гарын үсэг/**

**огноо**

Хавсралт №6

# ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХЯНАЛТЫН ХУУДАС

Төслийн нэр, хүч чадал, байршил....................................
Гэрээний дугаар.....................................................................
Гүйцэтгэлийн дугаар..............................................................
Гүйцэтгэгчийн нэр ................
Эрх нээсэн мөнгөн дүн /тоогоор, үсгээр/:

| Д/Д | Шалгуур үзүүлэлт, шаардлага | Тийм | Үгүй |
|---|---|---|---|
| 1 | Төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авах тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал, байршил нь хуулиар батлагдсан нэр томьёотой тохирч байгаа эсэх | | |
| 2 | Тендер шалгаруулалтын журмыг зөв сонгосон эсэх *Нийт төсөвт өртөг нь ТБОНӨХБАУХА хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтэрсэн бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна, түүнчлэн хуульд заасан шууд гэрээ байгуулах нөхцөл үүссэн байж болно/* | | |
| 3 | Тендерийн урилга, баримт бичгийг бэлтгэх, гэрээ байгуулахдаа төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан холбогдох журам, заавар, жишиг баримт бичгийг үндэслэл болгосон эсэх | | |
| 4 | Хуульд заасан хугацаанд, гэрээ байгуулах эрх олгосноос хойш ажлын 6 өдрийн дараа гэрээ байгуулсан эсэх, тендер шалгаруулалтын үр дүнг tender.gov.mn-д оруулсан эсэх | | |
| 5 | Захиалагч худалдан авах ажиллагааг баталгаажуулсан тодорхойлолт */яамдын хувьд ТНБД-ын, орон нутгийн хувьд аймаг, нийслэлийн ЗД-ын гарын үсэгтэй байх/* ирүүлсэн байх | | |
| 6 | Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний нийт үнэ эрх бүхий байгууллагаар батлагдсан төсөвт өртгөөс хэтрээгүй эсэх | | |
| 7 | Гэрээний үнийг үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн эсэх | | |
| 8 | Санхүүжилт авах тохиолдолд энэ журмын 11 дүгээр зүйлд тусгагдсан материалыг бүрэн ирүүлсэн байна | | |
| 9 | Тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон санхүүжилт хүссэн албан бичигт ТЕЗ-ийн томилсон эрх бүхий албан тушаалтнууд бүгд гарын үсэг зурсан эсэх | | |
| 10 | Санхүүжүүлэх дүн нь сар, улирлын батлагдсан хуваарийн дахь өссөн дүнгээс хэтрэхгүй эсэх | | |
| 11 | Тоног төхөөрөмж хүлээн авсан акт болон урьдчилгаа төлбөр, гүйцэтгэлийн баталгаанууд батлагдсан маягтын дагуу гаргагдсан эсэх | | |
| 12 | Төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлсэн ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан эсэх | | |
| 13 | Төсвийн тухай хуулиар батлагдсан төлөвлөгөөнд тусгагдаагүй ажлыг гэрээлж, хийлгээгүй байх | | |
| 14 | Тоног төхөөрөмж худалдан авалт нь хувийн, эсхүл өмчийн бусад хэлбэрийн этгээдийн өмчлөлийн зүйлд хийгдээгүй байх, төрийн болон орон нутгийн өмчлөлд бүртгэгдэх боломжтой эсэх | | |
| 15 | Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд хамрагдаагүй эсэх | | |

*Тайлбар:*
*"Тийм/Үгүй" гэсэн баганад "Тийм", эсхүл "Үгүй" гэсэн үгнээс өөр тэмдэглэгээ хийхгүй.*

**ХЯНАЛТЫН ХУУДСАНД ТУСГАГДСАН БҮХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ ХАНГАГДСАНЫГ ҮНДЭСЛЭН САНХҮҮЖИГДЭХ АЖЛЫН ЖАГСААЛТАД ТУСГАХЫГ ЗӨВШӨӨРСӨН:......................................................................../Нэр, Гарын үсэг/**

**ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД ХАНГАГДАЖ БУЙ ЭСЭХИЙГ ХЯНАН ШАЛГАЖ, ХЯНАЛТЫН ХУУДСЫГ БӨГЛӨСӨН:......................................./Нэр, Гарын үсэг/**

**ОГНОО**

Хавсралт №7

# УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТ

***БАТЛАВ:***
***ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ, ЭСХҮЛ ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ***

***Тамга***
*Гарын үсэг* *Нэр*

***Санхүүжилтийн хүсэлт № ...***

Гүйцэтгэгчийн нэр

*Он сар өдөр* /төгрөг/

| Хуулийн дугаар | Төсөл, арга хэмжээний нэр | Гэрээний дүн | Тухайн онд батлагдсан санхүүжилт | Гэрээний дугаар | Нийт гүйцэтгэл | Нийт санхүүжилт | Өмнөх санхүүжилт | Одоо санхүүжих | Үлдэгдэл санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | /төсөл, арга хэмжээний нэр/ барилга угсралтын ажлын гүйцэтгэл ...... | | | | | | | | |
| | Урьдчилгаа санхүүжилт | | | | | | | | |
| | Урьдчилгааны эргэн төлөлт | | | | | | | | |
| | Төсвөөс давсан гүйцэтгэл | | | | | | | | |
| | **Санхүүжилтийн эрх нээлгэх нийт дүн** | | | | | | | | |
| | Захиалагчийн хяналтын зардал | | | | | | | | |
| | Норм нормативын сан | | | | | | | | |
| | Барьцаа | | | | | | | | |
| | **Гүйцэтгэгчид төлөх дүн** | | | | | | | | |

***Хянасан:***
*Холбогдох газрын дарга* *Гарын үсэг* *Нэр*
*Холбогдох хэлтсийн дарга* *Гарын үсэг* *Нэр*

***Боловсруулсан:***
*Холбогдох мэргэжилтэн* *Гарын үсэг* *Нэр*

Хавсралт №8

**БАТЛАВ:** Захиалагч................................../Гарын үсэг, огноо/

*/Төсвийн ерөнхийлөн захирагч, эсхүл төсвийн шууд захирагч/*

Захиалагч: ____________________
(байгууллагын нэр тамга/ тэмдэг)

Гүйцэтгэгч: ____________________
(байгууллагын нэр тамга/ тэмдэг)

**БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ № ....**

1. Барилга байгууламжийн нэр, байршил: ..................
2. Хүчин чадал: ............................
3. Гэрээний дугаар: .......................
4. Эхлэх ба дуусах хугацаа: ......................
5. Гүйцэтгэл гаргасан хугацаа: ......................

(Төгрөгөөр)

| № | Зардлын нэр, төрөл | Төсөвт өртөг | Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл | Урьд авсан санхүүжилт | Тайлант үеийн гүйцэтгэл | Хянасан гүйцэтгэл | Зардлын төсөв өртөгт эзлэх хувь | Үлдэгдэл санхүүжилт |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ажиллах хүчний зардал | | | | | | | |
| 2 | Материалын зардал | | | | | | | |
| 3 | Машин, механизмын зардал | | | | | | | |
| 4 | Тээврийн зардал | | | | | | | |
| **Шууд зардлын дүн** | | | | | | | | |
| 5 | Нэмэгдэл зардал | | | | | | | |
| 6 | Ашиг | | | | | | | |
| **Барилга угсралтын ажлын дүн** | | | | | | | | |
| 7 | НӨАТ | | | | | | | |
| 8 | Нормчлолын сан | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |
| 9 | Техник хяналтын зардал | | | | | | | |
| 10 | Зураг төслийн үнэ | | | | | | | |
| 11 | Зохиогчийн хяналтын зардал | | | | | | | |
| 12 | Барилгад угсрагддаг тоног төхөөрөмжийн зардал | | | | | | | |
| 13 | Магадалшгүй ажлын зардал | | | | | | | |
| **БҮГД ДҮН** | | | | | | | | |
| **Бодит ажлын явц (хувиар)** | | | | | | | | |

Гүйцэтгэлийг хүлээн авч хянасан:

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
/ТЕЗ-ийн томилсон албан тушаалтнууд байна.
Жишээлбэл:

Санхүү, хөрөнгө оруулалтын газар/
хэлтсийн дарга...............................................
Албаны дарга ...............................................
Хяналтын инженер ........................................
Нягтлан бодогч ..............................................

Гүйцэтгэл гаргаж, хүлээлгэн өгсөн:

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Захирал .........................................
Ерөнхий инженер........... ..............
Ер. Ня-бо ........................................

Хавсралт №9

**БАТЛАВ:** Захиалагч....................................../Гарын үсэг, огноо/
*/Төсвийн шууд захирагч, эсхүл ТЕЗ-ийн томилсон албан тушаалтан/*

**БАТЛАВ:** Гүйцэтгэгч: ........................................../Гарын үсэг, огноо/

............................. **АЖЛЫН БАРИЛГА УГСРАЛТ/ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ҮЕ ШАТНЫ ХУВААРЬ,** хуанлийн хоногоор
*/Төсвийн хөрөнгө оруулалтын ажлын нэр, хүч чадал, байршил, гэрээний дугаарыг бичнэ/*

| д/д | Гүйцэтгэх ажлын нэр төрөл | Сар | ...-р сар | | | ...-р сар | | | ...-р сар | | | ...-р сар | | | ...-р сар | | | ДҮН |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | 10 хоног | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | 1 | 2 | 3 | |
| 1 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 2 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 3 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 4 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 5 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 6 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 7 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 8 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| 9 | | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |
| | **БҮГД ДҮН** /сая төг/ | Төл. | | | | | | | | | | | | | | | | |
| | | Гүйц. | | | | | | | | | | | | | | | | |

Хянасан:

Захиалагч:............................................../ТЕЗ-ийн томилсон албан тушаалтны гарын үсэг, тамга тэмдэг, огноо/
Гүйцэтгэгч:............................................../Захирал, талбайн инженер, нягтлан бодогч, гарын үсэг, тамга тэмдэг /

Хавсралт №10

БАТЛАВ:
Төсвийн шууд захирагч/ТЕЗ-ийн томилсон албан тушаалтан

............................/гарын үсэг, огноо/

## УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР БАРИГДАЖ БУЙ БАРИЛГЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, САНХҮҮЖИЛТИЙН ......-Р САРЫН МЭДЭЭ

201.... оны .....сарын ......-ны өдөр

| д/д | Барилга байгууламж, их засварын ажлын нэр, хүч чадал, байршил | Эхлэх дуусах | Төсөвт өртөг | 201... онд санхүүжих | Санхүүжилт /сая төг/ | Ажлын гүйцэтгэл */ажил тус бүрээр бодит гүйцэтгэл, хувийг бичнэ/* | 1.Тендер зарласан огноо<br>2. Гэрээ байгуулсан огноо | Тендерт шалгарсан гүйцэтгэгч |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| | | | | | | | | |

Хянасан:

..............................Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга

/гарын үсэг, тамга тэмдэг/

Боловсруулсан:

..............................Мэргэжилтэн /гарын үсэг/

Хавсралт №11

# ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ ХҮЛЭЭН АВСАН КОМИССЫН АКТ

201... оны ... сарын ..-ны өдөр Дугаар ...... ...............хот/аймаг

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1.1 Гэрээний нэр, дугаар, огноо...................................................................

1.2 Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал ....................................................

1.3 Захиалагч байгууллага ...............................................................................

1.4 Гүйцэтгэгч байгууллага ...............................................................................

1.5 ......................-ийн 201..... оны ..... сарын .....-ны өдрийн ....... тоот тушаалаар томилогдсон .... хүний бүрэлдэхүүнтэй Тоног төхөөрөмж хүлээн авах комисс нь захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулсан ...... тоот гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг гэрээний хавсралт, ерөнхий болон тусгай нөхцөлд тусгагдсан шаардлагыг хангасан байдал, барааны чанар, тээвэрлэлт, хадгалалтын байдал болон тоног төхөөрөмжийн холбогдох баримтуудтай газар дээр нь танилцан шалгав.

1.6 Гүйцэтгэгч нь тоног төхөөрөмжийг 201.. оны ... дугаар сарын ...-ны өдөр гэрээнд заасны дагуу бүрэн нийлүүлж дууссан байна.

## ХОЁР.ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Тоног төхөөрөмжийг шалгаж үзээд, гүйцэтгэгч байгууллага гэрээний дагуу нийлүүлэгдэх тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн гэж дүгнэв.

2.2 Тоног төхөөрөмжийг захиалагч байгууллагын мэдэлд бүрэн шилжүүлж, ашиглалтад хүлээн авахаар шийдвэрлэв.

2.3 Тоног төхөөрөмж хүлээн авах комиссын акт, холбогдох баримт бичиг, материалыг 4 эх хувь үйлдэж, захиалагч, гүйцэтгэгч, Сангийн яам тус бүрт нэг хувийг хүргүүлнэ.

2.4 Энэ актаар хүлээн авсан тоног төхөөрөмжийн баримт бичгийн иж бүрдэл нь дараахаас бүрдэнэ. Үүнд:

а) Тоног төхөөрөмжийг дагалдах техникийн бусад баримт материал:

б) Баталгаат засварын хугацаа, холбогдох баримт:

в/ Бусад

## ГУРАВ.ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Нэр төрөл | Марк | Үйлдвэрлэсэн улс, байгууллага, огноо | Тоо, хэмжээ | Нэгжийн үнэ | Тээвэрлэлтийн үнэ */шаардлагатай бол бөглөх/* | Угсралт, туршилтын үнэ */шаардлагатай бол бөглөх/* | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | |
| 2 | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Комиссын дарга: ................................../Гарын үсэг, тамга тэмдэг, огноо/

Нарийн бичгийн дарга: ......................../Гарын үсэг, тамга тэмдэг,огноо/

Гишүүд: ................................................./Гарын үсэг, тамга тэмдэг, огноо/

Гүйцэтгэгч байгууллага: ....................../Гарын үсэг, тамга тэмдэг, огноо/

Хавсралт №12

## ГЭРЭЭ ДҮГНЭХ МАЯГТ

Он сар өдөр

| | |
|---|---|
| **Гэрээний нэр:** | |
| **Гэрээний дугаар:** | |
| **Захиалагч байгууллага:** | |
| **Гүйцэтгэгч байгууллага:** | |
| **Гэрээгээр ажил эхлүүлэх хугацаа:** | |
| **Гэрээгээр ажил дуусгах хугацаа:** | |
| **Гэрээний дүн:** | |

**Батлагдсан гүйцэтгэлийн дүн:** ................. *төгрөг*

**Санхүүжилтийн дүн:** ..................... *төгрөг*

| | | | |
|---|---|---|---|
| **Үүнээс: БУА** | | **Үүнээс олгогдсон:** | |
| **Техник хяналт:** | | | |
| **Зураг төсөл:** | | | |

| | |
|---|---|
| **Чанарын баталгаат хугацаанд байршуулсан мөнгөн дүн** *(төгрөгөөр* | |
| **Гүйцэтгэгчээс ажил дууссан тухай мэдэгдэл ирүүлсэн өдөр:** | *..... оны .......... сарын .................. өдөр*<br>*Дугаар: ...................* |
| **Комиссын актын дугаар:** | *..... оны .......... сарын .................. өдөр*<br>*Дугаар: ...................* |

***Гэрээний биелэлт, шийдвэрлэлт:***

| | |
|---|---|
| **Гэрээний биелэлт:** | *Жишээ нь:::: Ажил бүрэн дууссан. Комисс комиссын акт ..... оны .. дугаар сарын ...-ны өдрийн .............. дугаартай баталгаажсан.* |
| **Шийдвэр:** | *Жишээ нь:::::Иймд алданги тооцохгүйгээр барьцаа хөрөнгө .... хувь .......... төгрөгийг үлдээж үлдэгдэл санхүүжилтийг олгохоор шийдвэрлэв.* |

***ЖИЧ:*** *Гэрээ хангалтгүй дүгнэгдсэн тохиолдолд дэлгэрэнгүй хурлын тэмдэглэлийг доорхи заалтын дагуу хөтөлж заавал хавсаргасан байх.*

***Гэрээ дүгнэсэн:***

| *ЗАХИАЛАГЧ:* | | *ГҮЙЦЭТГЭГЧ:* |
|---|---|---|
| .......................... /...................../<br>........................ /...................../<br>хариуцсан мэргэжилтэн /.................../ | | "........................" ХХК-ний захирал:<br>/ ..................... / |

***Тэмдэглэлтэй танилцсан:***

| | | |
|---|---|---|
| Захиалагч талаас /дарга/:<br>/........................ / | | Захиалагч талаас , санхүү:<br>/........................../ |

Хавсралт №13

# ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ӨМНӨХ ОНД АШИГЛАЛТАД ОРСОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ТАЛААРХ ХҮСНЭГТЭН МЭДЭЭ

БАТЛАВ:

Төсвийн шууд захирагч/ТЕЗ-ийн томилсон албан тушаалтан

......................../гарын үсэг, тамга тэмдэг, огноо/

## АШИГЛАЛТАД ОРСОН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН МЭДЭЭ

/сая төг/

| № | Барилга байгууламжийн нэр, байршил | Барилга байгууламжийн огноо | | Ашиглалтад орсон | | Захиалагч байгууллага | Ашиглагч байгууллага | Гүйцэтгэгч байгууллага |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Эхэлсэн | Дууссан | Хүчин чадал | Хөрөнгийн дүн | | | |
| 1 | | | | | | | | |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| | НИЙТ ДҮН | | | | | | | |

Хянасан:

Санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан нэгжийн дарга ............................./гарын үсэг, тамга тэмдэг/

Мэргэжилтэн ............................. /гарын үсэг/

Мэдээ гаргасан:

Захиалагч байгууллагын дарга .......................... /гарын үсэг, тамга тэмдэг/

Мэргэжилтэн .......................... /гарын үсэг/

Хавсралт №14

# САНГИЙН ЯАМНЫ ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХАРИУЦСАН НЭГЖЭЭС ТӨРИЙН САНГИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН НЭГЖИД САНХҮҮЖИЛТИЙН ЭРХ НЭЭЖ ХҮРГҮҮЛЭХ МАЯГТ

| No | ID | Дугаар | Захиалагч | Төсөл арга хэмжээний нэр | Гүйцэтгэгч | Банк Данс | Мөнгөн дүн (төг) | Мэргэжилтэн | Гарын үсэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | | | | | | | | |

**Хяналтын хуудсанд тусгагдсан бүх шалгуур үзүүлэлт хангагдсаныг үндэслэн санхүүжих ажлын жагсаалтад тусгахыг зөвшөөрсөн**

Төсвийн хөрөнгө оруулалт хариуцсан нэгжийн дарга .................. /нэр, гарын үсэг/

Хавсралт №15

Төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем

## САНХҮҮЖИЛТИЙН ХҮСЭЛТИЙН МАЯГТ №1

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Хуулийн дугаар: ...........

Төсөл, арга хэмжээний нэр: ..................................

Гэрээний дугаар: .....................

Гүйцэтгэгч: .......................    Ажлын явц: ......%

Хүсэлтийн дүн: .................. сая төгрөг

publicInvestment.gov.mn    Хэвлэсэн огноо:

Хавсралт №16

Барилга, объектын нэр_________

**ЗУРАГ ТӨСӨЛ ЗОХИОГЧИЙН ХЯНАЛТЫН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГДСЭН АКТ № ........**

1. Гэрээний дугаар__________
2. Гүйцэтгэл гаргасан _____он____сар____өдөр
3. Гэрээ эхлэх, дуусах хугацаа____________

(төгрөг)

| д/д | Зардлын ангилал | Төсөвт өртөг | Ажил эхэлснээс хойших гүйцэтгэл | Урьд авсан санхүүжилт /өссөн дүн/ | Тайлангийн үеийн гүйцэтгэл | ХЯНАСАН |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Ажлын хөлс | | | | | |
| 2. | Материаллаг зардал | | | | | |
| 3. | Унаа/замын зардал | | | | | |
| 4. | Албан томилолт | | | | | |
| | Дүн | | | | | |
| 5. | Удирдлагын зардал | | | | | |
| 6. | Ашиг | | | | | |
| | Дүн | | | | | |
| 7. | НӨАТ | | | | | |
| | Дүн | | | | | |
| 8. | Хэмжилт, шалгалт, лабораторийн зардал | | | | | |
| | Дүн | | | | | |
| 9. | Нэмэлт ажил | | | | | |
| | Нийт дүн | | | | | |

**ГҮЙЦЭТГЭЛИЙГ:**

*Хянасан:*

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

/ТЕЗ-ийн томилсон албан тушаалтнууд байна.
Жишээлбэл:

Санхүү, хөрөнгө оруулалтын газар/
хэлтсийн дарга.............................................
Албаны дарга ...............................................
Хяналтын инженер ........................................

Нягтлан бодогч ..............................................
Мэргэжилтэн .................................................

*Гаргасан:*

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Захирал ..........................................
Багийн ахлагч ........... ..............
Инженерүүд /БД, ББ, ХАС, ЦБУ, ДГ, ХД/ ..................................................
Нягтлан бодогч .....................................